

Гүнзгий мэд

MONGOLIAN ECONOMY

2016 оны 04 сар №07 (109)

mongolianeconomy.mn


Найдлага тээх нь бизнесийн
стратеги биш

Зөнгөөр нь орхичихвол

Үл итгэм



**Сургамж
сорилт
шийдэл**





*Өөрлөлтийг
мэдэр*

☎ 976-330505

f Petrovis Group

📷 Petrovismn

🐦 Petrovismn

ДЭЛХИЙН ХӨТӨЧ

Бүтэн жилийн турш таны ширээн дээр



“Mongolian Economy” сэтгүүл “The Economist” сэтгүүлийн жилийн “The World in 2016” дугаарыг тусгай зөвшөөрлийн хүрээнд монгол хэлээр гаргаад байна.

Дэлхий 2016: Энэ оныг гурван үгээр дүгнэж болох.

ЗОВЛОН ЗҮДГҮҮР, ЭМЭГТЭЙЧҮҮД болон ЯЛАЛТ.

Энэ удаагийн дугаарт Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Модри зэрэг нөлөө бүхий улстөрчдөөс гадна тусгай бүлэгт Канадийн зохиолч, Америкийн чиг хандлага ажиглагч, Израилийн шинэлэг загвар зохион бүтээгч болон Австралийн алдартай зурхайч гэх мэтийн хүмүүс хувь нэмрээ оруулжээ. Тус сэтгүүлд дэвшүүлэн тавьсан таамаг төлөвийн 90 хувь нь биелдгээрээ давуу талтай гэдгийг үг сэтгүүлийн эрхлэгч Даниел Франклин онцлон тэмдэглэсэн. Тийм учраас сэтгүүлийн байнгын уншигчид жил бүр эргэн ирдэг.

Бид Монголын уншигчдыг ч энэ эгнээнд элсүүлж чадсандаа баяртай байна. Та бүхэн таалан уншина уу.

Үнэ: 40.000₮

Утас: 7011 5477, 7011 5476, 88006228, 94092904

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ,

ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

О.Түвшин

СЭТГҮҮЛЧИД:

Б.Үүрийнтуяа

Б.Энхцэцэг

Г.Орхон

Ц.Элбэгсайхан

ОРЧУУЛАГЧ:

Б.Энхмөнх

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариамбаатар, Чингэлтэй дүүрэг, I хороо, Экспресс тауэр, 1101 тоот

Вэб:

www.mongolianeconomy.mn

И-мэйл:

info@mongolianeconomy.mn

Утас: 976-7011 5476

Борлуулах цэгүүд:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантүлхүүр” номын дэлгүүр

“Номин” супермаркетин бүх салбар

“Макс” супермаркетин бүх салбар

“Фреско” супермаркет

BTSI супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн:

“Grand plaza”

“Metro mall”


“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр

“Max mall” дахь салбарууд


 facebook.com/
Mongolian.Economy

 twitter.com/
EconomyMongolia

 youtube.com/user/
MongolianEconomy

Эдийн засаг

- 8 **Ухарч алхахаа больё**
“Эдийн засгийн суурь үзүүлэлтүүд муу байна. Валютын нөөц бага болсон. Уул уурхай гэсэн нэг салбараас хэт хараат тогтолцоо хэвээр байгаа нь ямар үр дүнд хүргэж байгааг өнөө үед ялангуяа маш их мэдэрч байна
- 9 **Бүргэд гэж бодсон болжмор байж**
Төр буруу бодож биднийг ийм байдалд хүргэлээ гэх хэсэг бий. Хэсэгчлээд үзвэл үнэн.
- 11 **Шинэ Монголын төлөө**
2030 он хүртэлх хөгжлийн үзэл баримтлал мөн өмнөхүүдийн адил цаасан дээр үлдэхгүй гэх баталгаа байна уу гэдэгт анхаарал хандууллаа.
- 16 **Найдлага тээх нь бизнесийн стратеги биш**
Бизнесийг зөвхөн нэг хэсгийг бус цогцоор харах нь чухал. Борлуулалт маркетинг гэдэг амин сүнс нь.
- 21 **Дампуурлын зүг урагшаа**
Дэлхийн банк энэ жилийн Монголын эдийн засгийн өсөлтийг 0.8 хувь болтол бууруулан таамагласан.
- 22 **Мөнгөний дэд бүтэц**
Олон улсын хөрөнгө оруулалт татарч байгаад Хятадыг тойрсон бүс нутгууд болон Өмнөд Африк, Хойд Америкийн эдийн засгууд буюу уул уурхайтай холбоотой эдийн засгууд нэрвэгдэж байна.
- 25 **Бизнес загвараа өөрчилье**
Монголчууд өнөөдөр үндсэндээ нэг л төрлийн бизнес эрхэлж байна. Тэр нь түүхий эдийн нийлүүлэлт. Сул талыг нь хангалттай мэдэрч байна.
- 26 **Зөнгөөр нь орхичихвол**
Монгол төр Улаанбаатар хотын гэр хороолол руу эргэн харж, тэнд амьдарч байгаа бүх хүн байранд орохоор тооцоолж алдаатай бодлого явуулсан гэж шүүмжлэх хүн цөөнгүй.
- 29 **Монгол хуульчдын өрсөлдөх чадвар**
Хууль эрх зүйн шинэтгэл явагдаж, тогтвортой байдал хангагдсанаар улс орны эдийн засгийн хөгжил эрчимждэг.
- 30 **Шуурхай чанар ба сайн бүтээл**
Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл нь сэтгүүлчийн ёс зүйн алдаа дутагдлын дагуу арга хэмжээ авдаг бие даасан байгууллага болон төлөвшиж байна.
- 34 **Амьдралын хуримтлал**
1979 оноос хойш төрсөн Монгол Улсын иргэн тэтгэврээ нэрийн дансны тогтолцоогоор тогтоолгоно.
- 36 **Үл итгэм**
Өнөөдөр жилдээ 1200 гаруй хүн элэгний хатуурлын улмаас нас барж байгаа гэх статистик байна.



Бүргэд гэж бодсон болжмор байж

Өөрчлөлт үгүй бол ахиц боломжгүй зүйл. Сэтгэлгээгээ өөрчилж чадахгүй хүн өөр юуг ч өөрчилж чадахгүй хэмээн Английн зохиолч, Нобелийн шагналт Жорж Бернард Шоу хэлжээ, хуудас 9



Найдлага тээх нь бизнесийн стратеги биш

Хүн гоё ярьсанд биш, хэлснээ хийж байгаа эсэхт л итгэнэ. Оюутолгой явж байгааг тэд мэдэж байгаа, хуудас 16



Зөнгөөр нь орхичихвол

Үл хөдлөхийн шинжээчдийн таамаглаж буйгаар үнэ цаашид ч буух нь. Учир нь нийлүүлэлтийн өнөөгийн эрчийг эрэлт гүйцэхгүй байгаа тул үнэ өсөхгүй байх бодит шалтгаан болж байна., хуудас 26



ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Монголын эдийн засгийн чуулган 2016 “Сургамж, Сорилт, Шийдэл” сэдвийн дор гуравдугаар сарын 30, 31-нд долоо дахь жилээ Төрийн ордонд зохион байгуулагдах гэж байна. Форумын уриа, хоёр өдрийн нээлтийн үг, гадна, дотнын хүндтэй зочин гээд тус чуулганы тогтсон загвар, бусдаас ялгарах онцлогийг харуулсан зүйлс байдаг. Зохион байгуулагчдын зүгээс хувийн хэвшил, төр засгийн байгууллагууд, судлаачдын төлөөллийг өргөн бүрэлдэхүүнтэй оролцуулж, эдийн засаг, улсын хөгжлийн өргөн хүрээтэй асуудлуудыг хөндөж олон талын байр суурийг гарган тавьж, мэтгэлцүүлж,

ойлголцолыг бий болгодгоороо онцлогтой. Чуулганы сонгосон сэдэв тухайн жилийн турш нийгэмд хэлэлцэгддэг нь цаг үеийн асуудлыг урьдчилан харж, дүгнэн цэгнэсэн сэдэв сонгодогтой холбоотой болов уу. Тухайлбал, өнгөрсөн жил гэхэд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ уруудсан, гадаадын хөрөнгө оруулалт огцом унасан, Засгийн газар тогтвортой биш болсон зэрэг эдийн засгийн таагүй уур амьсгалыг “Итгэлцэл” сэдвийн дор зангидаж, олон талын ухаан бодлыг уралдуулсан. Түүний өмнөх жил буюу 2014 онд “Монголдоо бүтээцгээе” уриатай болсон. Тэгвэл энэ жил өнгөрсөн жилүүдийн сургамж юу байсан, бидний өмнө ямар сорилт байгаа, шийдэл нь юу байх вэ гэдгийг хэлэлцүүлж, ирээдүй рүү итгэлтэй алхахыг зорьжээ.

Манай “Mongolian Economy” сэтгүүлийн хувьд ч гэсэн 2011 онд үүсэн байгуулагдсан цагаасаа уг форумд тасралтгүй мэдээллийн ивээн тэтгэгчээр ажиллаж, хэлэлцэх сэдвүүдийн хүрээнд олон талын байр суурийг урьдчилан хөнддөг онцлогтой билээ.

Энэ удаа дэлхийн болон Монголын эдийн засгийн төлөв, уул уурхайгаас авсан сургамж, чадварлаг төр, монгол залуусын мөрөөдөл, мэргэжлийн ёс зүй, нийгэм дэх эмэгтэйчүүдийн манлайлал, хуульчдын өрсөлдөх чадвар, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого гээд олон шинэлэг сэдэв оруулж иржээ. Манай сэтгүүлээс ч энэ талаар шинэ, сонирхолтой мэдээллүүд авах боломжтой. Түүнчлэн Монголын эдийн засгийн форум жил бүр гаднаас хүндтэй зочин урьдаг уламжлалтай. Энэ удаа АХБ-ны Зүүн Азийн бүсийн захирал Аюуми Кониши, Байгалийн баялгийн засаглалын институцийн ерөнхийлөгч ноён Даниел Кауфман нарыг урьж, оролцуулж байна. Тэдний чуулганы индэр дээрээс хэлэх үг оролцогчдод сонирхолтой, шинэ мэдээлэл байх нь дамжиггүй. “Монголын эдийн засгийн чуулган-2016”-д амжилт хүсье. ■

ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ И.ОТГОНЖАРГАЛ

Дэлхий дахинд

Йемен

Саудын Араб тэргүүтэй эвсэл болон Ираны дэмжлэгтэй дайчдын хоорондох дайн нэг жилийн ойг тохиолдуулан мянга мянган йеменчүүд гуравдугаар сарын 26-нд улсын нийслэл Санаа хотноо жагслаа. Хуситууд Йемен улсыг бүрэн хяналтдаа оруулахаас сэргийлж, мөн Ерөнхийлөгч Абд-Раббу Мансур Хадигийн засгийн эрхийг дахин тогтоохын тулд Саудын Араб тэргүүтэй эвсэл дайнд нэгдсэнээс хойш 6200 гаруй хүн амь үрэгдсэн байна. Хуситууд 2014 оны есдүгээр сард улсын нийслэл Санаа хотыг эзэлсний дараагаар Хади нийслэл хотыг орхиоос өөр аргагүйд хүрсэн юм. Саудын Араб тэргүүтэй цэргийн хүчнийхэн уг явдлаас хойш зургаан сарын дараагаар Хадигийн талд дайтаж эхэлсэн аж. Уг эсэргүүцлийн жагсаал НҮБ-ээс ирэх сард зохион байгуулах гал зогсоох энхийн хэлэлцээрийн өмнөхөн болж байгаа бөгөөд 2011 онд тухайн үеийн Ерөнхийлөгч Али Абдулла Салехыг огцроход хүргэсэн томоохон олон нийтийн жагсаалаас хойш болж буй томоохон тэмцэл ажээ.

ОХУ-Чечень

Өнгөрсөн онд болсон сөрөг хүчний улстөрч Борис Немцовын аллагад чеченчүүд холбоотой гэх цуурхалыг үл харгалзан Чечений удирдагч Рамзан Кадыровыг Владимир Путин дахин нэр дэвшүүлжээ. Кадыров өмнө нь босогчдын нэг байсан бөгөөд түүний эцэг Ахмат-Хаджи Кадыров 2004 онд тэсрэх бөмбөгт өртөж нас барах хүртлээ Москвагийн дэмжлэгтэйгээр Бүгд Найрамдах Чечень улсыг удирдаж байсан юм. Түүнийг нас барснаас хойш Рамзан эрх мэдлийг гартаа авч, Кремлийн мөнгөөр Грозный хотыг орчин үеийн тэнгэр баганадсан барилгуудтай хот болгоод байгаа билээ. Сүүлд болсон ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулиар Чечень муж дахь сонгуулийн ирц 99.6 хувьтай байсан бөгөөд сонгогчдын 99.7 хувь Путинд санал өгсөн аж. Кадыровын Москвад үзүүлсэн үнэнч байдлын хариуд Кремль түүнд Чеченийг хүссэнээрээ удирдах эрхийг олгосон хэмээн шүүмжлэгчид хэлж байна.

Шри Ланка

Өнгөрсөн лхагва гаригт Шри Ланка улсын Ерөнхий сайд Ранил Викремесинг тус улс БНХАУ-тай нэг тэрбум ам.доллараар үнэлэгдэх валют солих хэлэлцээр хийж байгааг парламентад мэдэгджээ. Тэрбээр “Бид гадаад валютын нөөцтэй холбоотой хэд хэдэн асуудалтай байна. Энэтхэг

улстай валют солилцоог хэдийнэ хийсэн бол одоо Хятадын Төвбанктай нэг тэрбум гаруй ам.доллараар үнэлэгдэх валютын солилцоог хийх болно” гэв. Энэ сарын эхээр Шри Ланка улс Энэтхэгийн Төвбанктай 700 сая ам.долларын валютын солилцоо хийсэн юм.

Катар



Дэлхийн хөлбөмбөгийн аварга шалгаруулах ФИФА 2022 наадмыг өөрийн нутагтаа зохион байгуулах Катар улсад цагаач ажилчдын боолчлолоо зогсоох 12 сарын хугацаа өгсөн бөгөөд эс бөгөөс тус улс НҮБ-ын шалгалттай нүүр тулах нь. Хэрэв тус улс уг сануулгыг хэрэгжүүлэхгүй аваас НҮБ-ын Олон улсын хөдөлмөрийн байгууллагаар албадан шалгуулсан 50 дахь улс болох юм. Өмнө нь Бирм, Гайти, Либерти болон Португал улсыг албадан шалгаж байжээ. Албадан шалгалт явуулсан тохиолдолд олон улсын хориг арга хэмжээ авахад хүргэх ч магадлалтай юм. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын төлөөлөгчид

энэ сард тус улсад ажилласны үр дүнд цагаач ажилчид гадаад паспортоо хураалгаж, олон сарын турш цалингүй хаашаа ч хөдлөх гарцгүй болсныг илрүүлсэн байна. Япон улсаас Женев дэх НҮБ-д суух Элчин сайд Мисако Кажи тэргүүтэй төлөөлөгчид эрүүл мэндийн үйлчилгээ авах ямар ч боломжгүй, өрөнд баригдсан бөгөөд ямар ч бичиг баримтгүй цагаач ажилчидтай уулзжээ. Тэд ажилчдын байртай танилцаж хамгийн доод стандартад ч хүрэхгүй болохыг харжээ. Ажилчдын сууцны нэг жижиг өрөөнд 10-12 ажилтан амьдардаг бөгөөд гал зуух болон өрөө нь ариун цэврийн стандарт хангах ямар ч нөхцөлгүй байсан гэлээ.

Цаг уурын өөрчлөлт

Цаг уурын шинжээчид өнгөрсөн хоёрдугаар сарыг түүхэнд тэмдэглэгдсэн хамгийн дулаан сар болсон гэж мэдэгдсэн бөгөөд ингэснээр өнгөрсөн арванхоёрдугаар сард тэмдэглэгдсэн рекордыг эвджээ. Өнгөрсөн хоёрдугаар сарын дэлхийн температурын өсөлт 1951-1980 оны хоорондох дундаж

температурын түвшнээс 1.35 градусаар өндөр үзүүлэлт бол аж үйлдвэржилтийн өмнөх үеэс 1.63 градусаар илүү аж. Парисын цаг уурын өөрчлөлтийн талаарх хурлаар ярьсан дэлхийн температурын өсөлтийг 1.5 градусаас хэтрүүлэхгүй байх асуудал хоёрдугаар сарын хувьд талаар болжээ. ▶

▶ АНУ-ын эдийн засаг

АНУ-ын эдийн засаг 2014 оны туршид 2.4 хувьтай өссөн хэмээн тооцоолж байна. Уг тоон баримтыг шинэчилсэн шалтгаан нь албан тушаалтнуудын анх бодож байснаас хавьгүй илүү хэрэглээний зарцуулалт гарсанд байгаа бөгөөд энэ нь тус улсын хөдөлмөрийн зах зээлийг сайжруулсан байна. Нэмэгдсэн ажлын байр аажмаар цалин болон орон сууцны үнийг нэмэхэд тус болсон бол газрын тосны хямд үнэ

АНУ-ын айл өрхүүдэд мөнгөө өөр зүйлд илүү зарцуулах боломжийг олгожээ. Хүчтэй өсөлтийн хувь дөрөвдүгээр сард уулзах Холбооны нөөцийн банкыг бодлогын хүүгээ нэмэх магадлалыг өндөрсгөж байгаа аж. Холбооны нөөцийн банк гуравдугаар сард болсон уулзалтаар бодлогын хүүгээ өөрчлөөгүй бөгөөд тэд үүнийг удаширч буй дэлхийн эдийн засаг АНУ-ын зах зээлд эрсдэл учруулж болзошгүй хэмээн тайлбарласан юм.

Алибаба

Хятадын цахим худалдааны тэргүүлэгч “Алибаба” компани өнгөрсөн онд гурван их наяд юанийн (462 тэрбум ам.доллар) бараа бүтээгдэхүүнийг өөрсдийн цахим хуудсаар дамжуулан борлуулсан хэмээн мэдэгдлээ. Тус компанийн дэд захирал Жо Цай хэлэхдээ гуравдугаар сард дууссан төсвийн жилээс 10 хоногийн өмнө энэхүү амжилтад хүрсэн гэжээ. Гурван их наяд юань нь “Алибаба”-гийн 2012 онд үзүүлсэн хэмжээнээс гурав дахин, 2013 оны худалдаанаас

хоёр дахин их үзүүлэлт аж. Хэрэв “Алибаба” энэ эрчээ алдалгүй явж чадах аваас тус компани АНУ-ын конгломерат Уол-Мартын дээр гарч дэлхийн хамгийн том жижиглэнгийн худалдааны сүлжээ болох юм. Уол-Мартын орлого сүүлийн таван жилийн турш өсөж байсан ч энэ онд удаширч эхэлсэн аж. Тус компанийн орлого өнгөрсөн онд 485 тэрбум ам.долларт хүрч, энэ оны хоёрдугаар сард дууссан төсвийн жилийн эцэст дээрхээс даруй тэрбум ам.доллараар буурчээ.

Европын Холбооны авлига

Европ дахь авлига жилд бараг 800 тэрбум фунт стерлингийн алдагдал учруулдаг болохыг Европын парламентын хийсэн судалгаа харуулсан бөгөөд тус судалгаагаар Румын, Болгар болон Хорват улс Европын хамгийн их авлигад автсан улс болжээ. Энэхүү алдагдал нь ЕХ-ны 28 улсын ДНБ-ий 6.3 хувьтай тэнцэж байгаа бөгөөд авлига хээл хахуулийг дарах Европын прокурорын газар байгуулах санал дэвшүүлсэн байна. Тус судалгаагаар улсын худалдан авах ажиллагаатай холбоотой авлигын улмаас жилд ойролцоогоор таван

тэрбум евро алддаг болохыг тогтоожээ. Худалдан авах ажиллагааны авлигад зориуд компаниудыг тендерийн явцад шахан, гаргаж зөвхөн нэг компанийг сонгох зэрэг авлигын үйл ажиллагаа багтдаг аж. Судалгаагаар Их Британи Европын авлигад хамгийн бага автсан улсын зургаад жагссан бол тус улсын урд Люксембург, Нидерланд, Швед, Финланд болон Дани улс орж байгаа юм. Харин Зүүн Европын улсууд бүгд ЕХ-ны авлигын дундаж түвшнээс дээгүүр үзүүлэлттэй байгаа бөгөөд 28 гишүүн орны хамгийн доогуур жагссан байна.

Иран

Ираны Ерөнхийлөгч Хассан Роуханы Пакистанд хийсэн хоёр өдрийн айлчлалын үеэр Өмнөд Азийн бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд бүс нутгийн холбоо ба хамтын ажиллагааг дээшлүүлэхийг уриаллаа. Руханы Пасиктаны Ерөнхий сайд Наваз Шарифтай уулзсан бөгөөд хоёр улсын хамтын ажиллагаа

болон бүс нутагт тогтвортой байдал тогтоох хамтын хүчин зүтгэл зэрэг харилцан сонирхлын хүрэн дэх асуудлуудыг ярилцсан юм. Тэрбээр өөрийн айлчлалыг өндөрлөх үеэр Исламабад хотноо сэтгүүлдэд “Бидний гол зорилгуудын нэг бол дэлхийн бусад улстай илүү сайн эдийн засгийн харилцаа тогтоох бөгөөд

Мьянмар



Сүүлийн 56 жилийн хугацаанд анх удаа ардчилсан сонгуулиар гарч ирсэн засгийн газар ажлаа авсны дараагаар цэргийн улс төрийн хүч байсаар байх шаардлагатай хэмээн Мьянмарын зэвсэгт хүчний ерөнхий командлагч хэлжээ. Хэдийгээр цэргийнхэн өнгөрсөн арваннэгдүгээр сард ардчилсан лидер Ан Сан Су Чигээр тэргүүлүүлсэн намын ялалт байгуулсан түүхэнд тэмдэглэхүйц сонгуулийг зохион байгуулахад Засгийн газар болон ард иргэдтэй хамтран ажилласан ч улс төрийн тавцангаас буух хараахан болоогүй хэмээн тэрбээр цохон тэмдэглэв. Үүний зэрэгцээ Ан Сан Су Чи 2013 оны аравдугаар сард Англи-Пакистан гаралтай сурвалжлагч Мишал Хусайнтай хийсэн ширүүн ярилцлагын дараагаар “Надаас Муслим хүн ярилцлага авна гэж хэн ч хэлээгүй” гэж хэлсэн гэх цуурхал олон хүн түүнийг буруушаахад хүргэсэн байна. Туршлагатай сэтгүүлч Хусайн ВВС агентлагийн ярилцлагын үеэр Су Чигээс Буддын шашин давамгайлсан Мьянмар улсад хамгийн их хүчирхийлэл болон дарангуйлалд өртдөг рохиньячуудын талаар ширүүхэн асуулт тавьж байсан юм.

тэр дундаа бүс нутгийн найрсаг харилцаатай улсуудтай харилцаагаа улам өргөжүүлэх юм” гэжээ. Бямба гаригт болсон Пакистан-Ираны бизнес форумын үеэр хоёр улсын лидер аль аль нь үг хэлсэн бөгөөд хоёр улс 2021 он гэхэд 5.0 тэрбум ам.долларын худалдаа хийхийг зорьж байна хэмээн Шариф хэлсэн юм. ■



Эдийн засгийн чуулган

Ухарч алхахаа больё

Б.ТУЯА

Майкл Жэксонь Moonwalk бүжгийг мэдэх хүн олон байх. Алхаж буй ч ухрах тэр хэмнэлээр манай улсын эдийн засаг 2012 оноос хойш явлаа. Дөрвөн жилийн өмнө дөрвөн тэрбум гаруй ам.долларт хүрч үнэлэгдэж байсан гадаадын шууд хөрөнгө оруулалт 2006-2007 оны түвшинд очиж буурсан. Өрийн дарамтад орох эрсдэлтэй гэгдэж байсан улс өнөөдөр дампуурах магадлалтай орнуудын тоонд оржээ. Олон улсын валютын сангийн Өрийн тогтвортой байдлын дүн шинжилгээнээс Монголын Улсын гадаад өр 2012 онд ДНБ-ий 15 хувьтай тэнцэж байсныг харж болно. Тэгвэл өнөөдөр нийт өрийн ДНБ-тэй харьцах харьцаа 180 хувьд хүрсэн талаар ярьцгааж байна. Урагшилж байгаа статистик гэвэл ажилгүйдлийн түвшин, ядуурал, үүд хаалгаа барьсан аж ахуйн нэгжүүдийн тоо. Гадаад, дотоодын цөөнгүй байгууллагынхан өнгөрсөн оны таваарын ханшийн уналтад хамгийн их нөлөөлсөн хүчин зүйл нь Хятадын эдийн засаг удааширсантай холбоотой гэж үзжээ. Хэдий өнгөрсөн жил Хятадын үйлдвэрлэлд суурилсан өсөлт удааширсан нь үнэн боловч дэлхий

нийтээрээ хямарчихаагүй. Европ (бага ч гэсэн) өсөлт үзүүлсэн. Японд ч эерэг өөрчлөлт байлаа. Тэгэхээр бүхнийг Хятадад тохох нь эргэлзээтэй бөгөөд урт хугацааны турш даамжирч ирсэн ам.доллар болон таваарын ханшийн харьцаа энэ бүхний цаана байх магадлалтай гэсэн таамаг гараад буй.

Харин манай улсын хувьд байдал арай өөр. Учир нь Монголын эдийн засаг “хэлд” орохдоо хэдий уул уурхай гэж дуугараагүй ч гэлээ тус салбарт хэт суурилсантай холбоотой. Авдаг нь үндсэндээ Хятад. Худалдан авагч нь ганц тул түүнээсээ хэт хараат. Нэмүү өртөг, солонгорсон эдийн засаг гэх мэтээр ярьсаар хийж чадалгүй сэргэлтийн үеэ өнгөрөөсөн учир энэ удаа алдаагаа биш шийдэл ярих хэрэгтэй гэж үзэн энэ жилийн Монголын эдийн засгийн чуулганыг “Сургамж, Сорилт, Шийдэл” хэмээн сэдэвлэн зохион байгуулах болжээ. Монголын эдийн засгийн форумын гүйцэтгэх захирал Б.Лакшми “Улс болгон ямар нэг байдлаар сорилттой нүүр тулж байгаа. Эдийн засгийн хүндрэлүүдээ даван туулахын тулд бид хамтрах ёстой. Өнгөрсөн жилүүдэд

бид алдаагаа ярьсаар ирсэн. Шийдэл хөндөж байгаагүй” гэсэн юм. Өмнөх алдаануудаас үүдсэн сургамж бидэнд ямар сорилт бий болгож байгааг олж тогтоон тэдгээрт шийдэл хайж олох цаг, тулгамдаад буй. Бүдэрсэн бол босох хэрэгтэй. Уйлж, дуулж ханалаа. “Эдийн засгийн суурь үзүүлэлтүүд муу байна. Валютын нөөц бага болсон. Уул уурхай гэсэн нэг салбараас хэт хараат тогтолцоо хэвээр байгаа нь ямар үр дүнд хүргэж байгааг өнөө үед ялангуяа маш их мэдэрч байна” хэмээн Лакшми нэмж хэлсэн.

Уул уурхайг түшин алхах Монголын эдийн засаг хаана бүдэрсэнээ ойлгож байгаа. Гэвч бүдэрсэн чулуугаа тойрч дөрөв гаруй жил эргэлджээ. Зарим талаараа бүр ухрах гэж үзсэн. Одоо бол ухарч биш, урагшилж алхмаар байна. Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Б.Түвшинтөгс “Хятадын эдийн засгийн бүтэц өөрчлөгдөж байна. Энэ нь манай улсад ямар нөлөө үзүүлэхийг судлах хэрэгтэй. Монгол Улсын гол партнер өөрчлөлт хийж байхад бид ямар хариу үйлдэл үзүүлэх тухайгаа тодорхойлох, бодлогоо төлөвлөх ёстой болно. ▶

▶ Тэгэхээр худалдаа, хөрөнгө оруулалтын урсгалыг болон бүтцийн шинэчлэлтэй холбоотой асуудлуудыг хөндөх учиртай” гэв. Өрийн асуудал улам хүндэрч байгаа энэ үед гадаадын хөрөнгө оруулалт хэрэггүй гэж ярих хүмүүс бий. Гэтэл Монголын компаниудын хэдэн хувь нь эрсдэлээ даах хэмжээнд хүрч, хөрөнгөөр хахаж байгаа билээ. Хөрөнгө оруулалт татна гэхээр таатай нөхцөл бүрдүүлнэ гэх мэт амны уншлага болсон хэдэн саналаа ярьдаг. Б.Түвшинтөгсийн хэлж буйгаар хэдхэн зүйл өөрчлөөд гадаадын хөрөнгө оруулалт авна гэсэн хялбар шийдэл хайгаад нэмэргүй. Үүн дээр нэмээд улсад хуримтлал гэх зүйл алга. Бизнесийн таагүй орчин бол манай

улсын нэрийн хуудас болсон. Энэ бүхэн бидний хамраа сөхөж, хаврын тэнгэр шиг аашилж ирсэний гай гэдэг. Улс төрийн тогтворгүй байдал, буруу бодлогоог үр дүн ч гэх. Улс төрийн оролцоог хязгаарлах гэхээр механизм нь хялбар биш гэдгийг Б.Түвшинтөгс хэлсэн юм.

ОХУ, Хятад гэсэн том гүрнүүдийн дунд орших нь манай улсын хувьд боломж. Бас аюул. Тэдний давуу болон сул талуудыг сайтар мэддэг байж өөрсдийн сул талаа давуу болгон ашиглах боломжтой. Хятадын масс үйлдвэрлэлтэй бид өрсөлдөж дийлэхгүй. Ерөнхий сайд асан нь Монгол оймс гэж тунхаглаад ч гадаадад

авах хүн ховор. Газрын тосны хэрэглээ ОХУ-аас шууд хамааралтай. Олборлож, борлуулж ирсэн арвин түүхтэй. Гэтэл манайхаас газрын тос худалдаж авах хүн байлаа гэхэд яаж хүргэх үү гэдэг бас л асуудал. Байгаа нүүрсээ урд хөрш рүү ачих асуудлаар 10 гаруй жил маргаж байхад өрөмдөөгүй цооногуудаас тос олборлоод боловсруулна гэдэг холын ирээдүй. Алсын боломжуудаа яриад байдаг ч ойрын асуудлаа хөндөж байгаа нь өнөөгийн нөхцөл байдалд хөтөлсөн гэдгийг хаа хаанаа хүлээн зөвшөөрч буй. Шийдэл олох нь бидний хувьд том сорилтуудын нэг. Шийдэл гэхээр салбар болгонд боловсон хүчний асуудал маш том хөндөх сэдэв. ■

Сургамж, сорилт, шийдэл

Бүргэд гэж бодсон болжмор байж

Б.ҮҮРИЙНТУЯА

Өнгөрсөн жил бид алсын хараа гэж ярьсан. Тэр үед бидэнд алсаа харах зорилго байгаагүй гэдэгт санал нэгдсэн. Энэ жил сургамж ярьж байна. Сорилттой нүүр тулж, шийдэл хайж байна. Тэгвэл бид сургамж авах ямар алдаанууд хийсэн бэ гээд эргээд харвал дэлхийд хөтөлсөн уул уурхайн салбараа унагаачихжээ.


Монгол Улсын төсөв, эдийн засаг экспортод гарах таваарууд, хэрэгжихээр байсан хэдэн том төсөлд горьдлого тавьж байсан. Гэвч уул уурхайн бүтээгдэхүүний экспортын 90-ээд хувийг бүрдүүлж байсан нүүрсний салбар зогссон. Ашигт малтмалын бусад бүтээгдэхүүний эрэлт буурч ханш уруудав. Энэ бүхний буруу Хятадын эдийн засаг удааширнаас болсон гэж хаа сайгүй ярьж байгаа ч уул уурхайн салбарын царцанги байдал чухам юунаас үүдэв?

Буруутны алдаа

Төр буруу бодож биднийг ийм байдалд хүргэлээ гэх хэсэг бий. Хэсэгчлээд үзвэл үнэн. Уул уурхайг хөгжүүлж ямар зорилгод хүрэх байснаа

бүрэн ухааралгүй бодлогууд тодорхойлж байсантай маргаад байхгүй биз. Тухайн үед орлого бүрдүүлж байсан ганц салбараа АТМ гэж андуурсанаас болж Оюутолгой, Тавантолгойн асуудал гацаж, ажиллаж байсан хэдэн нүүрсний компани дампуурч эхэлсэн. Ингээд ирэхээр татварын орлогоос эхлээд төрийн үйлчилгээг санхүүжүүлэгч эх үүсвэрүүд тасарч эхэлсэн. Улмаар хэрхэн хөгжүүлбэл нийгэмд, улсад, бизнес, эдийн засагт өгөөжтэй байхыг анхаарч авч үзэлгүй уул уурхайг мөнгө олох хэрэгсэл болгож хувиргасан. Ингэхдээ хуулийн үндсэн үүргээ умаргаж үйлчлэгч биш өрсөлдөгч болж тоглоомд оролцох болсон. Олборлож байвал хэн ухах нь хамаагүй гэж дайрсан нь төрийн хамгийн том алдаа болсон гэдгийг хувийн хэвшлийнхний төлөөллүүд хэлж байгаа юм. Төр бол интитуци. Төрд олборлолт хийх мөнгө байхгүй, ажил нь ч биш. Ухдаг, олборлодог, ханган нийлүүлдэг, ажилладаг хэсэгт төр үйлчлэх ёстой байсан ч үүнийгээ биелүүлж чадаагүй. Үнийн мөчлөг тохиодог, үүнээс үүдээд

эдийн засгийн хүндрэл бий болж, өрийн дарамтад орох эрсдэлийг Голланд өвчин гэдэг тухай ярьж байсан ч ойлгож аваагүй нь бас нэг том алдаа болсон. Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Н.Алгаа “Монголын дотоод хүчин зүйлээс болоод хөрөнгө оруулагчид гараад явчихлаа. Алдаагаа засаад эхэлж байгаа ч тэд эргээд иртэл дор хаяж таван жил болох байлгүй. Тэгэхээр практик



шийдлүүд бидний алдсан итгэлцлийг сэргээхэд дөхөм болох юм” гэсэн. Уул уурхайг хөгжүүлэхийн үр өгөөж юу вэ гэдгийг ул суурьтай судлах ёстой. Бусад орны туршлагаас хуулж биш судлан суралцах ёстой. Гэтэл Нигерт хэрэгжиж байгаа хууль Монголд ч үйлчилнэ гэх өнгөц сэтгэлгээгээр энэ улсын төр түшиц салбараа хүчээр хөгжүүлэх гэж оролдсон. АНУ, Австрали, Сингапурт болдог юм байна гээд аваад орчуулаад маргааш нь мөрдөнө гэдэг мэдлэгтэй нийгэмтэй мэдлэггүйгээр өрсөлдөх гэсэн мунхаг бодол. Солонгост хэрэгтэй, япончуудын эрэлт гээд нэмүү өртөг шингээж экспорт хийнэ гэж дайрдаг нь манайхны зуршил. ▶

▶ Гэтэл хүний нөөц, чадамж гэдэг зүйл нь бий болоогүй. Хэнтэй өрсөлдөж ямар бүтээгдэхүүнийг аль стандартаар хүргэх үү гээд ухааж бодохгүйгээр үргүй зардал гаргаад байдаг. Тэгвэл дотоод хүчин зүйлс зөвхөн төрөөс хамаарахгүй. Хувийн хэвшил ч үүрэг оролцоотой. Тэд юун дээр алдсан гэдгийг сийрүүлэх гэж оролдоё.

Төрийн бодлого тогтворгүй байдаг нь хувийн хэвшилд алдаа хийх эрсдэлийг улам нэмэгдүүлдэг. Уул уурхайд хувиараа зүтгэгчдэд хуулийн дагуу олгосон лиценз, зөвшөөрлөө төр дур мэдээд хүчингүй болгодог явдал удаа дараа гарч байсан. Гэтэл хувийн хэвшил үйл ажиллагаа эхлүүлэх гээд зээл санхүүжилт олж тоног төхөөрөмж худалдан авахын зэрэгцээ ажиллах хүчинд хөрөнгө оруулчихсан байдаг. Үндсэн хуульд хуулийн дагуу хөдөлмөр эрхэлж, түүнийхээ орлого, үр шимийг хүртэх эрх бүрэн нээлттэй байдаг бөгөөд энэхүү эрхийг баталгаажуулан хамгаалах үүрэг төрд ногдог. Гэтэл төрийн ааш олдохгүй яривагтай тул хувийн хэвшлийнхэн хурган дарга нарын араас мөнгө барин гүйх, байгаль орчин сүйтгэх, нийгмийн хариуцлагаа ухамсарлахгүй байх зэргээр хууль бус зүйлд хутгалдаж өөрсөдөө занга үүсгэдэг нь тэдний хамгийн том алдаа гэдгийг МНГ группын ерөнхийлөгч Д.Жаргалсайхан хэллээ. Алгаа гуайн тайлбарласнаар бол нийгэм өөрчлөгдөж, хувийн хэвшил зохилоод ирэхээр тэд мэдлэг гэдгийг маш хурдан олж, шингээж авдаг байна. Гэтэл тэднийг чиглүүлэх засаглал нь хоцроод үлдчихээр түрүүнд алхаж буйгаа уургалах гэж оролддог. Ингээд хувийн хэвшил ч зүтгэх урамгүй болж хөгжил ч саарах нөхцөл бий болдог ажээ. Нөгөө талаар иргэдэд бас учир бий. Төр хувийнхныг хангалттай бөөрөлхөж байхад популизмын үндэсийг улам ургуулах нөхцлийг иргэд бий болгож буй. Дээрх гурван тоглогч хаа хаанаа хуульдаа захирагдаж, дүрмээ барихгүйн улмаас үүргээ ч умартаж эхэлсэн нь өнөөдрийн бидний яриад буй сургамжийн эх суурь болж байгаа юм.

Өөрчлөлт үгүй бол ахиц боломжгүй зүйл. Сэтгэлгээгээ өөрчилж чадахгүй хүн өөр юуг ч өөрчилж чадахгүй хэмээн Английн зохиолч, Нобелийн шагналт Жорж Бернард Шоу хэлжээ.

Цочироо өгөхөд

2011-2012 онд гарсан 17 хувийн өсөлт 10 гаруй жил үргэлжилнэ гэж ярьж байлаа. Гэтэл дөрөв хүрэхгүй жилийн дараа өнөөх өсөлт нь тэг рүү дөхөхөд бид зүүднээсээ сэргэж эхлэв. Сэрээд харгал монголчуудын төлбөрийн чадвар буурчихсан, төгрөг цаас болж халамжаас хамааралтай амьдарч, популизмээр тархиа угаалгаад эцэст нь тулга тойрсон хэрүүлээс өөр ярих сэдэвгүй үлджээ.

“Худал мэдлэгээс болгоомжил. Учир нь мэдэхгүй байхаас илүү хортой” гэж дээр дурьдсан зохиолч хэлсэн байгаа юм. Яг энэ л манай улсад тохиосон болж таарлаа. Цаг үе өөрчлөгдсөн ч өнөө л нүүдэлчин зангаараа сургийн мэдээллийг мэдлэгтэй андуурч явсан нь монгол түмнийг бүхэлд нь ялзруулж орхиж. Даван туулах гэхээсээ илүүтэй дасан зохицож, хариуцлага хүлээж бас нэхэж мэдэхээ байсан тухай Д.Жаргалсайхан ярьсан юм. Тэрбээр “Хүн алдаж байж сурдаг. Гэхдээ сургамж

авдаггүй хүмүүс бий. Яагаад гэхээр алдаагаа ухамсарлахгүй бусдад тохдог учраас. Өнөөдөр ММС-ийн асуудлаар бүгд ярьж байна. Гэтэл энэ бол мөсөн уулын зөвхөн харагдаж буй хэсэг. ММС дампуурах гэж байна гэхээр баярлаж байгаа хүмүүс байх юм. Компани дампуурлаа гэхэд хэн хожих вэ? Тухайн байгууллагад ажиллаж байсан хүмүүс, ханган нийлүүлэгчид, хувьцаа эзэмшигчид, татвар авдаг төр бүгд хохирно. Энэ бүхэн юу хэлж байна гэхээр монголчууд мунхаг, харанхуй байна” хэмээн тайлбарласан.

Ашиг сонирхлоо тэргүүнд тавьж тэжээгч салбараа мөнгөөр үнэлж ирсэн нь бидний алдаа. Үр дүнгээс нь бид сургамж авч байна. Сорилт нь гэвэл бидэнд мэдлэг алга.

ЗМ буюу мэдлэг, мэдлэг, мэдлэг

Олон улсын 9001, 14001, 18001 стандартуудыг нэвтрүүлж буй компаниудынхаа тоогоор Хятад тэргүүлж байна. Мөнгө нь илүүдсэндээ биш. Хятад бүтээгдэхүүнүүдээ дэлхийд хүргэхийн тулд зах зээлийн шаардлагаа мэдэж байгаа учраас тэр. Гэтэл бид нүүрс манайх гээд гадаадын хөрөнгө оруулагч, төсөл хэрэгжүүлэгчдээ хөөгөөд явуулчихсан. Зөвхөн уул уурхайн салбараар жишээлэхэд төр, хувийн хэвшил, иргэний нийгэм гээд бүх түвшний шатлалд мэдлэг даанч дутмаг байна. Дэд бүтэц сул хэвээр байхад үүнийг шийдвэрлэх бодлого гаргаж чадаагүй л явна. Мэргэшсэн шинжээч, судлаач, инженерүүд зэргийг бэлтгэх, хүлээн зөвшөөрүүлэх чадамж маш сул хэвээр. Түүнчлэн ойлголцож, зөвшилцөн мэдлэгээ хуваалцдаг тогтолцоо систем бий болоогүй байгааг Н.Алгаа онцолсон юм. Тэрбээр “Хууль, дүрмүүдээ засч байгаа ч хэрэгжүүлэх чадамж гэж юм бий. Хүнээс шалтгаалах хүчин зүйлс хэтэрхий их байгаа нь мэдлэг дутмаг байгаагаар холбоотой. Улмаар чадамж үгүй болж хариуцлага ч байхгүй болж байгаа юм” гэсэн. Тэгэхээр бидний хийсэн алдаа мэдлэггүй байснаас үүдсэн бол сорилт ч мөн мэдлэг олж авах нь. Шийдэл ч ялгаагүй мэдлэгтэй холбоотой болж таарч байгаа юм.

Чөлөөт зах зээл, ардчилсан нийгэм гэж 25 жил явжээ. Энэ хугацаанд нутагшуулах нэрээр гаднаас хуулсан зүйлс их бий. Тэнд болсон юм энд ч болно гэж харанхуй зүтгэсэн учраас өнөөдөр бид мэдлэггүйгээ гайхаад сууж байгаа юм. Тодруулбал, далайд гарцгүй хэрнээ далайн эргийн үнээр нүүрс олборлогчдоосоо татвар тооцож буй явдал. Энэ талаар Н.Алгаа “Ямар зорилгоор байна уу гээд харахаар төсвийн орлогын нүдээр бүхнийг харж байна. Энэ жил, дараа жилийн төсөв. Гэтэл урт хугацаанд бизнесийг дэмжээд татвар төлөх бааз суурийг олон болгоод багыг олонтой нийлүүлээд түүнээс татвар авна гэсэн ойлголт байхгүй. Чадаж байгаагаас нь ихийг авна гэдэг. Мэдлэг энд ерөөсөө хамаагүй байна. Улс төр, төсвийн орлого хоёрт захирагдаад мэдлэгийг хаячихдаг. Татварын хууль тогтоомжийг боловсруулж, ногдуулж байгаа нөхдүүд ашигт малтмалын бүтээгдэхүүн, үнэ бүрдэлтийн талаар ямар ч ойлголтгүй байдаг. Тэднийг мэдлэгжүүлэх тал дээр хүсэл ч алга” гэж шүүмжлэв.

Олон улсад биднийг уул уурхайдаа бүргэд нь гэж бодтол үнэн хэрэгтэй болжмор байсныг монголчууд өөрсдөө харууллаа. Гэхдээ шударга болохоороо үнэнээ хэлээгүй. Мэдлэггүй бас сэтгэлгээний мухардалд орсон болохоор тэд бидний сул талыг олоод мэдчихсэнд учир байгаа юм. Асуудлын цөм нь хаана байсныг барагцаалж мэдлээ. Эхнээс нь цэгцэнд оруулж хэмжүүр тогтоовол системчилэх замаар шийдэлд хүрч болох юм. ■



Хөгжлийн бодлого

Шинэ Монголын төлөө

И.ОТГОНЖАРГАЛ

Ийм ардчилал, ийм нийгэм байгуулахыг бид хүсээгүй гэсэн утгатай өгүүлбэрийг сүүлийн үед хэн дуртай нь хэлж, халаглах болсон. Тэгвэл 25 жилийн тэртээ Үндсэн хуулиараа “... Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулна...” хэмээн тунхаглан хөгжиж буй эдүгээ цаг дор юу нь бидний хүсээгүй ардчилал гэж. Хувийн өмчтэй, олон их дээд сургуультай, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрхтэй, иргэний эрх хангагдсан, хүн бүр унаа машинтай хүссэнээрээ л эрх чөлөөтэй сайхан амьдарч байгаа юм биш үү? Мэдээж ардчиллын буянд гэж олзуурхах зүйл бишгүй бий. Мөн ийм ардчиллыг хүссэн бил үү гэж эргэлзэхэд хүргэж байгаа нь ч олон. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, эх нялхасын эндэгдэл, өмчийн эрхийн хамгаалал, боловсролын чанар гээд бүхний сэтгэлд нийцтэй биш олон асуудал бий. Тухайлбал, өдгөө нийгэмд талцал үүсгэж буй таагүй урхагтай

нэг асуудал бол орлогын тэгш бус байдлын тухай. Баян, ядуугийн ялгаа улам бүр ихэссээр. Энэ байдлаараа бол дээрх ялгаа цаашид бүр их холдохоор байгаа нь олон судалгаагаар гардаг. Үүний хамгийн санаа чилээх зүйл нь эрүүл нийгмийг илэрхийлдэг дундаж болон чинээлэг дундаж давхарга манайд бараг байхгүйтэй адил буй нь улсаараа унах аюултай ангал ойрхон байгааг илтгэх. Баян хүмүүс олон янз. Тэдний цөөнгүй нь маш их хөдөлмөрлөж, баялаг бүтээж баяжсан. Харин хүнд хүчир ажилд нухлагдаж, биеэ зовоохгүй, оюунаа чилээхгүйгээр гэнэт гэдэс нь цадсан нь ч олон. Үүнтэй холбоотойгоор сүүлийн үед нийгэмд нэг хэсэг нь ингэж амар хялбараар зовлогоо зовоохгүй баяжиж чадаж байхад би яагаад зовох ёстой гэж, үр хүүхдэдээ ч зовохгүйгээр баян тансаг амьдралд хүрэх боломжийг нь одооноос олгоё, зааж сургая гэх хандлага хавтгайрах шинжтэй байгаа нь ажиглагддаг. Нэг талаас харахад

хүн хөдөлмөрлөж л чадвал хүссэнээрээ сайхан амьдарч болох юм шиг нийгэм байгаа боловч хичээж, зүтгэж байгаад нь дэндүү хатуу, шангармаар орчин нөхцөлтэй. Хувийн хэвшилд ажиллаж ачааны хүндийг үүрч үзсэн, үзээгүй залуу үе боломжийн ажиллаж амьдрах талбараа төрийн албаар төсөөлж суух жишээтэй. Бүгдийг мөнгөөр шийднэ гэсэн хандлага гаарсаар байгаа учраас авлига хээл хахууль газар авсаар. За тэгээд баялаг бүтээж баяжсан нь ч байна уу, төрөөс төрсөн тэрбумтан нь ч байна уу ялгаагүй тэрбитгий хэл, үр хүүхэд нь хүртэл баалуулж амьдрах болчихоод байна. Ингээд бодохоор Монгол Улсын хөгжил хаашаа чиглэж, юуг зорьж яваа нь тун бүрхэг.

Арабын ядуу орнууд шиг болчихгүйн тулд цаг алдахгүй хуруу хумсаа хөдөлгөж, тархи толгойгоо чилээх учиртай. Одоогийн төр, засгийн түвшинд, эрдэмтэн судлаачидтай хамтраад илүү сайн сайхан нийгмийг бий болгохын төлөө ажиллаж, гаргасан ▶

▶ “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030” гэсэн баримт бичигт нэг найдаж үзэх юм. Уг баримт бичигээс харахад 2016 оны сонгуулийн дараах төр, засагт шинэ Монголыг цогцлоох цоо шинэ, хариуцлагатай үүрэг ногдох нь.

Манай улс өнгөрсөн хугацаанд нэг бус удаа сайхан зорилтуудтай тогтвортой хөгжлийн бодлогын баримт бичиг гаргаж байсан. Тухайлбал, 1996 онд Н.Багабанди УИХ-ын дарга байх үедээ “Монгол Улс ойд тойрсон сармагчин лугаа байж болохгүй” гэдэг санаачилга гарган Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлалыг УИХ-аар батлуулсан. Дараа нь Н.Энхбаяр Ерөнхийлөгч байхдаа 2008 онд гарсан Мянган хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ) гаргахыг санаачилж, УИХ-аар батлуулсан. Хамгийн сүүлд буюу гурав дахь нь танд танилцуулж буй “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030” юм. Цаасан дээр бодлогын баримт бичиг үйлдвэрлэснээрээ бол манайх аль хэдийнэ хөгжлийн манлайд хүрчих боллоо гэж шүүмжлэх хүн байна байх. Гэхдээ энэ удаагийн үзэл баримтлалыг өмнөхүүдтэй нь харьцуулж үзэхэд арай өөр. Бүрэн уншиж, танилцаад үзэхээр

хонгилын үзүүрт гэрэл асах магадлал байж болох тал бас байна.

Өмнөх хөгжлийн үзэл баримтлал болон хөгжлийн цогц бодлогод дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг үнэлж цэгнэж, урагшлах тал дээр манайхан учир дутагдалтай ажилласан тал бий. Тухайлбал, Мянган хөгжлийн цогц бодлогын нэгдүгээр үе шат өнгөрсөн онд дууссантай холбоотой Засгийн газар үнэлж дүгнэх ёстой байсан ч тэгээгүй. Тэгээд ч 2030 он хүртэлх үзэл баримтлалыг өнгөрөгч хоёрдугаар сард УИХ-аас баталсантай холбоотойгоор 1996 оны Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, 2008 оны Үндэсний хөгжлийн цогц бодлого тус тус хүчингүй болж байгаа юм. Гэхдээ ҮХЦБ-ын найман жилийн хэрэгжилтийг Засгийн газрын түвшинд эргэн харж үнэлж дүгнээгүй ч энэ асуудалд анхаарлаа хандуулж, уншиж судалж, ажиглаж байдаг судлаачдын төлөөлөл 50 хувийн биелэлттэй байсан хэмээн дүгнэсэн юм. Мянган хөгжлийн цогц бодлогод үндэслэсэн Үндэсний хөгжлийн цогц бодлогын биелэлтийг манай сэтгүүл хойно албан бус байдлаар сонирхуулж байгаа болно/. Хэдий хүчингүй болсон ч юу нь хэрэгжсэн, юу нь хэрэгжээгүй вэ гэдгийг анзаарахад илүүдэхгүй болов уу.

Тэгвэл 2030 он хүртэлх хөгжлийн үзэл баримтлал мөн өмнөхүүдийн адил цаасан дээр үлдэхгүй гэх баталгаа байна уу гэдэгт анхаарал хандуулаа. Уг үзэл баримтлалыг УИХ дээр хэлэлцэх үеэр хөгжлийг хэмжих тоон үзүүлэлтүүдийг хэт өөдрөг төсөөлсөн, хэрэгжих магадлал багатай байна гэсэн шүүмжлэл мэр сэр гарч байсан. Ажлын хэсгийн байр суурь өмнөх шиг нэр заасан олон зорилт багатай. Ерөнхий концепц уул уурхайд түшиглэх биш хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, ногоон эдийн засагт анхаарлаа хандуулснаараа илүү бодитой болсон гэж үзэж байгаа юм.

Хөгжлийн үзэл баримтлалд “Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно” гэж тусгажээ.

Мөн эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлэх зорилт тавьжээ. I үе шат /2016-2020/, II үе шат / 2021-2025/, III үе /2026-2030/ гэсэн шатлалтайгаар хэрэгжих аж. Нийгмийн тогтвортой хөгжлийн хувьд иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэх зорилт бий.

Үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр 2030 онд хүрэх үр дүнгийн 10 үзүүлэлт болон зорилтуудыг хэмжих 20 үндсэн үзүүлэлтийг та бүхэн хүснэгтээс сонирхуулаа. Энэ удаагийн үзэл ▶

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр Монгол Улс 2030 онд:

- | | |
|--|--|
| 1. Нэг хүнд ногдох үндэсний нийт орлог 17500 ам.долларт хүрч, нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрнэ | тогтолцоог бүрдүүлнэ |
| 2. Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 2016-2030 онд 6.6 хувиас доошгүй байна | 6. Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг хангаж, дундаж наслалтыг 78-д хүргэнэ |
| 3. Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно | 7. Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий эхний 70 орны нэг болно |
| 4. Орлогын тэгш бус байдлыг багасгаж, нийт хүн амын 80 хувь нь дундаж болон чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байна | 8. Экологийн тэнцвэртэй байдлыг хадгалж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болно |
| 5. Суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшинг 100 хувьд хүргэж, насан туршийн боловсролын | 9. Бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийн эхний 40 өрсөлдөх чадварын үзүүлэлтээр эхний 70 орны нэг болно |
| | 10. Хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвшсөн байна |

► баримтлалын өмнөх бодлогын баримт бичгүүдээс ялгарах нэг онцлог нь дэвшүүлсэн зорилтуудаа үнэлж хэмжих үзүүлэлтүүдийг тавьж өгсөн байгаа нь олзуурхуштай. Энэ талаар уул уурхайн эдийн засагч, МН группийн ерөнхийлөгч Д.Жаргалсайхан манай сэтгүүлийн өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын 22 дугаарт “Шчоошиг” гэдэг гарчигтай нийтлэл бичсэн билээ. Өмнөх хөгжлийн урт хугацааны зорилтуудад ийм хэмжих тоон үзүүлэлт байгаагүй учраас амжилт бүтээл, ажлын үр дүнгээ тоогоор илэрхийлэх дуртай бизнесмэнүүдэд тун таалагдсан гэсэн үг.

Дараагийн хэрэгжиж, үр дүн гаргах магдлалтай зүйл нь үзэл баримтлалыг УИХ-ын Нам, эвслийн бүлгүүдийн хамтарсан Ажлын хэсэг гарч, өргөн бүрэлдэхүүнтэй эрдэмтэн судлаачдын баг ажиллаж боловсруулсанд байгаа юм. Мөн өнгөрсөн оны арваннэгдүгээр сард баталсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуультай уяж өгсөн нь хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангах давуу тал болно. Үзэл баримтлалыг тус хуулиар тав таван жилээр задалж төлөвлөгөө болгож явах бөгөөд тэр төлөвлөгөө нь хуулийн дайтай байх нь. Өөрөөр хэлбэл, төлөвлөгөөнд орсон зүйл л төсөв дээр яригдана гэсэн үг. Төсөв хэлэлцэх үеэр УИХ-ын гишүүд дураараа дургидаг одоогийн оодорсон байдалд цэг тавина. Түүнчлэн НҮБ-аас Даян дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд 2030 гэсэн баримт бичгийг өнгөрсөн оны есдүгээр сард баталж гаргасан. Уг баримт бичиг Монголын хөгжлийн үзэл баримтлал-2030-ын чиг баримжаа болж байгааг онцолъя.

Энэ тогтолцоог бүрдүүлэхэд ирэх сонгуулийн дараах Засгийн газар тун чухал үүрэгтэй оролцох ёстой. Үзэл баримтлалд туссан нийгэм, эдийн засаг, засаглалын хөгжилтэй холбоотой олон чухал санааг зөв ойлгож, хийж хэрэгжүүлэх нь тэдний үүрэг. Ямар ч гэсэн хуулиар баталгаажсан 15 жилийн хугацаанд хөдлөшгүй мөрдөх хөгжлийн баримт бичигтэй боллоо. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Улсын их хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж байх юм. Монгол орны хөгжил мандан бадраг.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль

Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг доорх бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлнэ.

6 ДУГААР ЗҮЙЛ. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТӨРӨЛ

- 6.1. Хөгжлийн бодлогын баримт бичиг нь дэвшүүлж байгаа зорилго, зорилтоосоо хамааран дараах төрөлтэй байна:
 - 6.1.1. урт хугацааны;
 - 6.1.2. дунд хугацааны;
 - 6.1.3. богино хугацааны.
- 6.2. Урт хугацааны буюу 15-20 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал байна.
- 6.3. Дунд хугацааны буюу 8-10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх дараах хөгжлийн бодлогын баримт бичиг байна:
 - 6.3.1. төрөөс баримтлах бодлого;
 - 6.3.2. бүсчилсэн хөгжлийн бодлого;
 - 6.3.3. аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт.
- 6.4. Дунд хугацааны буюу 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх дараах хөгжлийн бодлогын баримт бичиг байна:
 - 6.4.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
 - 6.4.2. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр;
 - 6.4.3. үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөр;
 - 6.4.4. улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр.
- 6.5. Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх дараах хөгжлийн бодлогын баримт бичиг байна:
 - 6.5.1. улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
 - 6.5.2. аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл;
 - 6.5.3. Энэ хуулийн 6.5.1-д заасан үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулсан улсын болон орон нутгийн төсөв.

7 ДУГААР ЗҮЙЛ. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- 7.7. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтэд дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.
- 7.8. Засгийн газар Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээний тайланг Улсын Их Хуралд танилцуулна.
- 7.9. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, намуудын эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулна.
- 7.10. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, намуудын эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэхийг Үндэсний аудитын газар хянаж, Сонгуулийн ерөнхий хороонд дүгнэлтээ хүргүүлнэ. ►

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцыг дараахь 20 үндсэн үзүүлэлтээр тодорхойлж, үнэлнэ:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2014 он)	Зорилгот түвшин (2030 он)
1	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	хувь	7.8 6.	61
2	Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого	ам.доллар	4166	17500
3	Хүний хөгжлийн үзүүлэлт	эзлэх байр	90	70
4	Дундаж наслалт	жил	69.57	78
5	Ядуурлын түвшин	хувь	21.6	0
6	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	эзлэх байр	104	70
7	Бизнес эрхлэлтийн үзүүлэлт	эзлэх байр	56	40
8	Байгаль орчны багц үзүүлэлт	эзлэх байр	111	90
9	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан байдал	хувь	84.4	99
10	Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт	оноо	36.5	30.0
11	1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшин	промилль	15.1	8
12	100000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин	промилль	30.6	15
13	Ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт (улсын дундаж)	хүүхдийн тоо	27.3	20
14	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын хорно, цээрийн шаардлагад нийцсэн газар нутгийн эзлэх хэмжээ	хувь	0	60
15	Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хэмжээ	хувь	78.2	68
16	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ	хувь	17.4	30
17	Монгол Улсад аялах гадаад жуулчдын тоо	сая хүн	0.392	2.0
18	Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан өрх	хувь	89	100
19	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ	Хувь	17	50
20	Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх	Хувь	0	100

ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН I ҮЕ ШАТНЫ ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

2015 оны жилийн эцсийн байдлаар

I дүгээр үе шатанд хэрэгжүүлсэн байвал зохих зорилтууд

Хэрэгжсэн байдал

1.	Эдийн засгийн эрчимтэй, өндөр хурдацтай өсөлтийн үр дүнд ажлын байр олноор бий болж, хүн амын ядуурал 2 дахин буурах;	Ажлын байр нэмэгдсэн боловч ядуурал хангалттай буураагүй.
2.	Хүний хөгжлийн индекс 0.83 болох;	хүний хөгжлийн индекс 0.727 болж хангагдаагүй,
3.	3.5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 2000 оныхоос гуравны хоёроор, эхийн эндэгдлийг дөрөвний гурваар бууруулах,	Зорилт хэрэгжсэн.
4.	Хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолын халдварын тархалтыг тууштай бууруулах;	Зорилт хэрэгжээгүй.
5.	Бүх салбарт жендэрийн тэгш байдлыг хангахад мэдэгдэхүйц дэвшил гаргах;	Хэрэгжиж байгаа.
6.	Сургуулийн насны хүүхдийг бага боловсролд бүрэн хамруулж, хүйсийн ялгааг арилгах;	Бүрэн хамруулсан.
7.	Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлж, сургалтын олон хувилбарт төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх;	12 жилийн тогтолцоонд шилжсэн.
8.	Эдийн засаг жилд дундажаар 14-өөс доошгүй хувиар өсч, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 5000-аас доошгүй ам. долларт хүрэх;	Нэг хүнд ногдох орлого 4200 ам доллар, хэрэгжиж байгаа.
9.	Ашигт малтмалын олборлолт мэдэгдэхүйц нэмэгдэх, дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах салбарын эзлэх хувь 4 дахин өсч, өндөр технологи нэвтрэн, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар дээшлэх;	Зорилт хангагдаагүй.
10.	Нүүрснээс газрын тосны болон химийн бүтээгдэхүүн гарган авах үйлдвэрлэл бий болох,	Зорилт хангагдаагүй.
11.	Газрын тосны бүтээгдэхүүний дотоодын хэрэглээний 50-иас доошгүй хувийг өөрийн үйлдвэрлэлээр хангах;	Зорилт хангагдаагүй.
12.	Аялал жуулчлалын салбар хөгжиж, жилд нэг сая жуулчин хүлээн авах;	Зорилт хангагдаагүй.

13. Оюуны шингэц бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжиж, мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурь тавигдаж эхлэх;	Зорилт хангагдаагүй.	26. Гэр бүлийн хүчирхийллийг арилгах цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	
14. Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн таатай орчин бүрдэх, ажилгүйдэл мэдэгдэхүйц буурах;	Ажилгүйдэл буурсан.	27. Хамран сургалтын бохир жин бага боловсролд 99.1, дунд ангид 97.2, суурь боловсролд 98.3 хувьд тус тус хүрэх;	Хэрэгжиж байгаа.
15. Программ хангамжийн үйлдвэрлэл, экспортыг хөгжүүлэх боломж бүрдэж, хэрэглээ нэмэгдэх;	Зорилт хангагдаагүй.	28. Олон улсын жишигт нийцсэн болон түүнд ойртсон, төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын цогцолбор сургуулийн тоог 10-аас дээш болгох;	Зорилт хэрэгжсэн.
16. Нийслэлийн гэр хорооллын 20-30 мянгаас доошгүй өрх төвлөрсөн шугам сүлжээнд холбогдож, улсын хэмжээнд жилд дунджаар 10000-аас доошгүй өрх орон сууцны нөхцөлөө сайжруулах;	Зорилт бүрэн хангагдаагүй.	29. Олон улсын стандартад ойртсон хоёроос доошгүй их сургуультай болох;	Зорилт бүрэн хэрэгжээгүй.
17. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хүн амын хүнсний бүтээгдэхүүний хангамж сайжрах;	Тогтвортой сайжраагүй.	30. Өрхийн эмнэлгийн тогтолцоо бүрэн төлөвших;	Зорилт бүрэн хэрэгжээгүй.
18. Биотехнологи, генийн инженерчлэлийн аргыг нэвтрүүлэн малын үүлдэрлэг чанарыг сайжруулж, тарималын ургацыг нэмэгдүүлэх, улаан буудайн жилийн дундаж үйлдвэрлэл 4 дахин, төмс, хүнсний ногооны жилийн дундаж үйлдвэрлэл 1.5 дахин өсөх;	Зорилт хангагдаагүй.	31. Сум, аймгийн эмнэлгүүдийн 60 хувь дүүргийн эмнэлгүүд 100 хувь эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжөөр тоноглогдох;	Зорилт бүрэн хэрэгжээгүй.
19. Дэд бүтцийн салбарт томоохон зорилтуудыг хэрэгжүүлж, хатуу хучилттай авто замын урт 8000 км-т хүрэх,	Зорилт хэрэгжсэн.	32. Өвчний түүхийг бүрэн цахим картад шилжүүлэх;	Зорилт хэрэгжсэн.
20. Говийн болон зүүн бүсэд төмөр замын сүлжээ барих ажлын 60 хүртэл хувийг гүйцэтгэх, хоёр дахь төмөр зам барих ажлын 70-аас доошгүй хувийг хийнэ.	Зорилт хангагдаагүй.	33. Хөдөөнөөс оношилгоо, эмчилгээнд зорчигчдын тоо 50-иас дээш хувь буурах;	Хэрэгжиж байгаа.
21. Гол төмөр замыг цахилгаанжуулах ажлыг шийдвэрлэх;	Зорилт хангагдаагүй.	34. Олон улсын стандартад нийцсэн эмчилгээ-оношилгооны төвийг байгуулан ажиллуулж, гадаад явж эмчилгээ, оношилгооны үйлчилгээ авдаг иргэдийн тоог мэдэгдэхүйц бууруулах;	Хэрэгжиж байгаа.
22. Монгол Улсын бүх сум байнгын цахилгаантай болж, бүх малчин өрх нар, салхины эрчим хүчээр хангагдах,	Зорилт хэрэгжсэн.	35. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, чанар 75 хувьд хүрэх;	Хэрэгжиж байгаа.
23. Дотоодын эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангахаас гадна цахилгаан эрчим хүч экспортолж эхлэх;	Зорилт хангагдаагүй.	36. Улаанбаатар болон томоохон хотуудын агаарын бохирдлыг бүрэн арилгаж, хог хаягдлын цогц менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар орчны бохирдлын эх үүсвэрийг эрс багасгах;	Зорилт хангагдаагүй.
24. Бүс нутгуудын хөгжил түргэсч, Улаанбаатар хотын хүн амын хэт төвлөрөл саарах, бүсийн тулгуур төв зарим хотын хүн амын тоо 50 мянгаас доошгүй болох;	Зорилт хангагдаагүй.	37. Монгол орны экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдол бүхий тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, 2015 он гэхэд нийт нутаг дэвсгэрийн 20-иос доошгүй хувь буюу 30 гаруй сая га-д хүрэх;	Зорилт бүрэн хэрэгжээгүй.
25. Тавантолгой, Оюутолгой зэрэг стратегийн томоохон орд газруудыг түшиглэн орчин үеийн шийдэл бүхий 10-20 мянган хүнтэй хотууд бий болох;	Зорилт хангагдаагүй.	38. Хот суурин газрын хүн амын 70 хувийн, хөдөөгийн хүн амын 60 хувийн ундны усны хэрэгцээг хангасан байх.	Зорилт хэрэгжсэн.

Зорилтын хэрэгжилтийн байдлыг 2015 оны жилийн эцсийн байдлаар дүгнэж үзвэл:

Үндэсний хөгжлийн цогц бодлогын 1 дүгээр үе шатанд бүхий л салбарын хөгжлийн 38 зорилтоос найман зорилт хэрэгжсэн, 12 зорилт нь хэрэгжих шатандаа үргэлжлэн явж байгаа, харин 18 зорилт нь хэрэгжээгүй байна.

Үүнээс үзвэл 1-р шатны тавьсан зорилтуудын хэрэгжилт нь 2015 оны жилийн эцсийн байдлаар

50-53 хувьтай үргэлжилж байна гэж үзэж болохоор байна.

Зорилтыг хэрэгжүүлж чадаагүй үндсэн шалтгаан нь:

а) Хөгжлийн цогц бодлогод тодорхойлсон эдийн засаг, байгаль орчин, засаглалын талаар үүссэн эрсдэлийг урьдчилан хараагүй, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй, эрсдэлийг зохистой

удирдаж чадаагүйн улмаас олон тооны зорилт хэрэгжих боломжгүйд хүрсэн.

б) Бодлогыг хариуцан хэрэгжүүлэх үүрэг бүхий институцийг чиг үүргийн нь дагуу ажиллуулж чадаагүй, бодлогын тогтвортой байдал алдагдсан.
в) Гадаад эдийн засгийн орчин нөхцөл өөрчлөгдөж, экспортын орлого, гадаадын хөрөнгө оруулалт эрс буурсны улмаас төсөв, хөрөнгө оруулалтын боломж хумигдаж, хөрөнгийн эх үүсвэр дутагдсан. ■



Төсөл менежмент

Найдлага тээх нь бизнесийн стратеги биш

Б.ЭНХЦЭЦЭГ

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б. Бямбасайхантай ярилцлаа. Хэдийгээр бид олон сэдвийн хүрээнд хөөрөлдсөн ч төслийн менежмент, санхүүжилтийн талаар илүү дэлгэрэнгүй ярилцсан юм.

-Эдийн засаг хүндэрсэн энэ нөхцөлд бизнесийн үйл ажиллагааг хэрхэн савлуулахгүй авч явах вэ?

-“Rio Tinto”, “BHP Billiton” зэрэг том компаниуд гурван жилийн өмнөөс л бүх бизнесийнхээ хүрээнд зардлаа танаж эхэлсэн. Бага зардлаар ажиллаж байж хүнд нөхцлийг давна гэдэг стратегиа аль дээр боловсруулаад хэрэгжүүлж байна. Одоо бол маргааш үнэ өсчихнө гэдэг сэтгэлгээгээр бизнес

хийдэггүйг ойлгож байна, бүгдээрээ. Найдлага тээх нь стратеги биш гэдэг үг бий. Байдал сайжирна гэх хүлээлт ялангуяа уул уурхайн бизнест тохирохгүй. Тиймээс өнөөдрөөс л шинэчлэл хийх хэрэгтэй. Бид үргэлж “дараа жил” гэж ажлуудаа хойшлуулж явлаа. Үүний дүнд бизнесийн зардал улам өсөөд л байна. Зах зээл унаад байхад зардал өсөөд л байвал дампуурна, ойлгомжтой. Тэгэхээр бид бизнесийн ▶

► 20, 30 жилийн цаадахыг бодолцсон стратеги дээр үндэслэн төлөвлөлтүүдээ хийх чадавхитай байх шаардлагатай. Сүүлийн таван жилд зөвхөн дотоод бус гаднын зах зээлд өрсөлдөх шаардлагатай болсон учир өнөөдрийн монгол маягийн бизнес явуулдаг арга барилыг нэгмөсөн өөрчлөх ёстой гэдэгт би итгэдэг. Дэлхийн стандартад л нийцэж ажиллах хэрэгтэй. Түүнээс завсрын, монгол гэх мэтээр яваад болно гэж бодож байгаа бол таван жилийн дараа гэхэд зарим бизнес үгүй болчихсон байх биз.

Зэс, алт, нүүрс, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний үнэ сүүлийн 10 жилийн доод түвшиндээ хүрсэн. Энэ үед яаж өрсөлдөх чадвартай байхыг сайн тооцоолох хэрэгтэй. Өнөөдөр тохиож буй энэ байдал ирээдүйд дахиад ч давтагдана. Уурхайн бизнесийг бид өмнө нь нүүрс, хүдрээ ухаж аваад вагонд ачих гэж ойлгоод байлаа. Тэрнээс цааш олон шат дамжлага бий. Бизнесийг зөвхөн нэг хэсгийг бус цогцоор харах нь чухал. Борлуулалт маркетинг гэдэг амин сүнс нь. Тэрийг зөв хийвэл олон улсын зах зээлийн үнээр буюу ямарваа нэгэн хямдралгүйгээр бүтээгдэхүүнээ зарна. Манай компаниудын хувьд үүнийг сайн ойлгож дүн шинжилгээ хийж, түүн дээрээ үндэслэн зохих өөрчлөлтүүдийг хийж байна. Бизнесийн энэ арга барилыг ойлгох, дэд бүтцийг хурдан гартаа оруулах шаардлага бий.

-Эдийн засгийн хүндрэлээс бид ямар сургаж авч байна вэ?

-Мэдээж хэрэг бид сурч байгаа. Бидэнд бизнес эрхлэх 25 жилийн туршлага л бий. Түүнээс өмнө бизнесийн менежмент гэж юм байсангүй. Одоо бол өдөр бүр энэ тал дээр чамбайрж байна. Компани жижиг, том ч бай удирдлага нь байдал хүндрэхэд мөнгөн урсгалаа тогтвортой барина гэдэг хамгийн чухал гэдгийг бид ойлгож байна. Юм болгон дээр асар их ашиг хийдэг үе өнгөрсөн. Ирээдүйд тийм үе ирж магадгүй л дээ. Гэтэл тогтмол мөнгөн урсгалтай байвал тогтвортой үйл ажиллагаагаа олон жил авч явж болно. Мөн бүх зардлаа хасаад тодорхой ашгаа хувьцаа эзэмшигчдэд хуваарилаад байж болно. Мөн эдийн засгийн талаас харвал тогтмол мөнгөн урсгалтай үед л ажлын байр бий болдог. Мөнгөн урсгалаа сайн тооцож, тогтвортой байлгахыг хичээж байна. Зах зээлд тодорхой компаниуд энэ талаа тогтвортой байлгах боломж бий. Зах зээл муудсан ч унтарчихаагүй байгаа. Хятадын өсөлт удааширч байна гээд байгаа ч өссөөр л байна. 13 их наяд ам.долларын эдийн засаг зургаан хувиар өснө үү долоон хувиар өснө үү цаашид өсөх нь тэртээ тэргүй абсолот хэмжээгээр өндөр. Тэр өрсөлдөөнд манай бизнес хамгийн бага зардалтай байвал ялна.

-“Эрдэнэс Монгол” компани шинэ технологи, менежментээр хувийн компани шиг ашигтай ажиллана гэх зорилгоо хэрхэн биелүүлэх гэж байна вэ?

-Зарим хүмүүс манай компанийг төсвийн мөнгөөр үйл ажиллагаагаа явуулдаг төрийн байгууллага гэж боддог. Үгүй, “Эрдэнэс Монгол” бол ХХК. Өмнө нь ашигтай ажиллах боломж гараагүй. Учир

нь, тодорхой хэмжээний хөрөнгө босоод ирэхээр Хүний хөгжлийн сан руу татчихдаг байсан. Саяхан хуулинд өөрчлөлт орж, нэгдүгээрт Компанийн тухай хуулийн дагуу компани шиг ажиллана, хоёрдугаарт хэрвээ энэ компани ашигтай ажиллавал мөн үүний зэрэгцээ олон улсын зах зээлээс нэмэлт санхүүжилт таглаа гэхэд тэр мөнгөөрөө салбар бизнесүүдээ санхүүжүүлэх боломж бүрдсэн гэж болно. Энэ бол суурь өөрчлөлтүүд. Бид дэлхийн нэг хэсэг болохын хувьд олон улсын стандартаар тоглохгүй бол болохгүй нь. Олон стандартыг өөрсдөө бий болгож зардал мөнгө цагаа үрж байснаас нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын стандартыг дэлхийн компаниуд шиг дагаад үйл ажиллагаагаа явуулах хэрэгтэй болчихоод байна. Жишээ нь санхүүгийн стандарт их чухал. Тайлан балансыг чинь уншаад ойлгохооргүй байвал хэн санхүүжилт хийх юм. Ном ёсны дагуу судалгаа, ТЭЗҮ хийж байж хөрөнгө оруулалтаа шийднэ. Түүнээс биш өнөөдөр энэ экскаватор эвдэрлээ ийм юм авья гэдэг байж болохгүй. Товчхондоо энэ шүү дээ. Мэдээллийн технологийг компанийн ажиллагаанд зөв нэвтрүүлэн сайн ашиглаад явбал манай үр ашиг жилд 10 хувиар нэмэгдэнэ. Хувийн компаниуд бүх ажлаа, гэрээгээ и-мэйлээр хийж болоод байхад төрийн өмчит компаниуд нь заавал албан тоотоор гэж шаарддаг утгагүй зүйлс байна. Үүнийг өөрчлөх хэрэгтэй. Мэдээллийн технологи Монголын бизнесийн орчинг тэр аяар нь хурдтай, өрсөлдөх чадвартай болгож байхад төрийн өмчит компаниуд түүнийг ашиглахгүй бол өрсөлдөөнд ялагдана.

Бидний эхний гол зорилго бол одоогийн байгаа хөрөнгө буюу компаниудаа үр ашигтай ажиллуулах. Бизнес ашигтай байж л хувьцаа эзэмшигчиддээ үр ашгаа өгнө. Энэ бол цогц бизнес учир нэгийг үлдээвэл бүгд нурах аюултай гэж ойлгох хэрэгтэй. Зарим нь техник технологи л шинэчилчихвэл ашигтай болчих мэт боддог. Гэхдээ үүнээс гадна техник технологийг хэрхэн үр ашигтай ашиглах вэ гэдгийг сурах хэрэгтэй. Бид Азийн хөгжлийн банктай хамтарч ажиллаж байна. Удахгүй зээлийн асуудлаа шийдүүлээд санхүүгийн менежментийн технологио шинэчлэх, удирдлагаа сайжруулах, том төслүүдээ боловсруулах үйл явцыг санхүүжүүлнэ.

-Танай компани төр, хувийн хэвшлийн аль, алины шинж агуулсан үйл ажиллагаатай байгаа болохоор хүний нөөцийн ямар бодлоготой байгаа вэ?

-Бид Монгол стандартаараа ажиллаад байвал ажиллах хүч хангалттай байна. Олон улсын стандартаар ажиллах шаардлага тулгарч байгаа тул үүний дагуу ажиллах хүмүүс хэрэгтэй. Менежмент технологийн шинэчлэлийн хажуугаар түүнийг ашиглах мэдлэг чадвартай хүн хэрэгтэй. Бид тийм хүмүүсийг ажиллуулахыг зорино. Чадахгүйгээ чаддагынх нь хажууд дагалдуулж сургана. ►

Бизнесийн арга барилыг ойлгох, дэд бүтцийг хурдан гартаа оруулах шаардлага бий.

► Туршлагатай мэргэжилтэнг бид зах зээлийн таарсан нөхцөл цалингаар ажиллуулна. Түүнээс биш эх орондоо хайртай учраас та энд ирээд цалин багатай ажил гэдэг арга барил хаана ч боломжгүй. Төрийн өмчит компани болохоор бага цалинтай ажилла гэдэг бол хулгай хийх мандатыг өгч байгаагаас ялгаагүй. Хүнд таарсан шан харамжийг нь өгвөл тухайн хүн хэзээ ч өөрийн хоол олж иддэг тогооноосоо хулгай хийхгүй. Чадваргүй хүнийг хямд ажиллуулна гэдэг зардал багасгаж буй хэрэг явч биш.

-Чамгүй олон төсөл дээр ажилласны тань хувьд төслийн санхүүжилт яагаад шинжлэх ухааны судлагдахуун болтол хөгжихсөн тухайд.

-Төсөл үр ашигтай эсэхийг тооцож үзсэнийхээ дараа яг ямар аргаар санхүүжүүлэх вэ, /equity/үндсэн хөрөнгө мөн /debt/ зээл хэд байх вэ гэх мэт бүгдийг тооцож, эргээд төслөөс гарах мөнгөн урсгалтай нь уяж үзээд, ийм хэмжээний хөрөнгө оруулалт хэрэгтэй гэж шийдээд банкууд дээр очно. Зарим үед бүх санхүүжилтийг нэг банкаас зээлчихгүй.

Олон банктай хамтарч босгоно. Нийт санхүүжилтээ бүх банктайгаа нэгмөсөн тохирсны дараа ажлаа эхэлдэг. 100 төгрөг хэрэгтэйгээс 90 төгрөгтэй болчихоод сүүлийн 10 нь байхгүй байвал ажлаа эхлэлтгүй. Энэ бол зарчмын том асуудал. Үүнийг “Financial close” гэж нэрлэдэг. Хөрөнгө мөнгөө нэг мөр шийдээд тэгээд энэ төслийн барилгын явцыг тасралтгүй явуулах нь бизнесийн хувьд байнгын үр ашигтай байна. Хэрвээ дундаа тасарчихвал зардал л нэмэгдэнэ. Бид Оюутолгой /ОТ/ дээр олон улсын санхүүгийн байгууллагуудаас 4.4 тэрбум ам.долларыг босгож чадаж

байгаа нь энэ төсөл өмнөх бүх шатаа зөв давж чадсанд оршиж буй. Өөрөөр хэлбэл, менежмент, хүдрийн чанар, Монгол, Хятадын эдийн засаг, дэд бүтэц гэх мэт олон талаас нь судлаад ийм байна гэж нарийн тооцоод гэрээ байгуулж бидэнд мөнгө зээлүүлж байна. Юмаа ном ёсоор нь хийсний дараа хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргадаг байх нь зүйтэй. ТЭЗҮ байхгүй төсөл дээр хөрөнгө оруулах шийдвэр гаргачихаад, мөнгө нь бүрэн шийдэгдээгүй байхад ажлаа эхлүүлээд явангуут буруудаад урагшиллж чадахгүй гацчихсан бодит жишээнүүд Монголоор дүүрэн байна. Дампуурсан нь ч байна.

Өнөөдөр ОТ дэлхий нийтээр хэрэгжиж буй хамгийн том уул уурхайн төсөл. Хөрөнгө оруулалтын гэрээ сайн уу, муу юу гээд яриад байгаагийн цаана 6500 монгол хүн ажилтай, дэлхийн хэмжээний бизнес болчихсон байна. Хамгийн том татвар төлөгчийг 4-5 жилийн дотор бий болгочихлоо. Цаашлаад монголчууд нь илүү нарийн мэргэжилтэй болоод зарим нь өөр улсуудад нэр хүндтэй ажиллаж байна. Дээр нь бизнесийн олон улсын стандартыг хэвшүүлж байна. Та ямар ч том даргыг таньдаг байлаа ч ОТ-той бизнес хийхэд нөлөөлөхгүй. Сүүлийн жилүүдэд улс төрөөс ангид бизнес хийж болдогийг манай

компаниуд ойлгоод ажиллаад явж байна. ОТ дээр олон улсын банкууд орж ирснээр байгаль орчин, үйл ажиллагааны нарийн ажиллагааны стандартуудыг бүрдүүлж байгаа.

-Оюутолгойн санхүүжилтийн хэлэлцээр нэлээд удаан хугацаанд үргэлжилж байна. Зарим хэлцлүүд одоо ч үргэлжилсээр. Удаж буй шалтгаан нь юу вэ?

-Хүнд шаардлагууд тавиад байгаадаа биш л дээ. Банкууд зохих шаардлага л тавьж байгаа. Хэрвээ та мөнгө хүнд зээлж байгаа бол тэр мөнгийг эргүүлээд олж авах эсэхт итгэлтэй байхыг хүсэх нь зүйн хэрэг. Үүний тулд тогтсон горим стандартаа ашиглана. Төслийн санхүүжилт гэдэг эрсдлийг хуваах механизм юм. Хэн нь аль эрсдлээ дааж чадахаа тохироод гэрээ хэлцлээ хийдэг. Эрсдлээ ингэж хуваарилсны дагуу мөнгө босгож ашигладаг.

Оюутолгойн гүний уурхайн хувьд ажлуудаа нарийн төлөвлөчихсөн, гүйцэлдүүлээд явж л байгаа шүү дээ. Хэт найдварт баригдсан хэвээрээ л байна. 2009 онд ОТ гэрээ зурагдахад хоногийн дараа бүх юм өөрчлөгдөөгүй. Харин өөрчлөлт гурван жилийн дотор явсан. Өнгөрсөн наймдугаар сараас хойш бид тодорхой төсөв батлаад бэлтгэл ажлыг санхүүжүүлээд явж байна. Тодорхой шинэ ажлын байрууд бий болсон. Том гэрээнүүд зурагдахын өмнө тендерүүд явж байна. Аливаа том төслийг хэрэгжүүлэхэд чадвартай компаниудыг дотоодын болон гаднын зах зээлээс сонгон шалгаруулж, гэрээнүүдээ хийнэ. Та бид хоёрыг ингээд ярилцаад сууж байхад монгол, гадаад компаниуд тендерийн материалаа өдөр шөнөгүй бэлдээд, эсвэл гэрээ хэлцэл хийгээд явж байх жишээний. Одоо хэзээ мөнгө орж ирэх вэ гэдэг гэнэн асуултаас салъя. Мөнгө гэрээнүүд зурагдахаар орж ирнэ. ТУЗ-өөр шинэ төсөв батална. Тоон үзүүлэлтүүдээ шинэчилж, хараад, нарийн үр ашгаа тооцож, мөнгөн урсгалаа яаж барих вэ гэдгийг бодож, зээлээ цагт нь төлөх тооцоо хийнэ.

-Одоо Оюутолгойд улс төрийн нөлөөлөлд орохгүйгээр цаашаа явах баталгаа бий юү?

-ОТ бол бизнес болохоос улс төр биш. Гол зорилго нь бизнес үр ашигтай ажиллаж, баялаг бүтээгээд эзэндээ өгөөжөө өгнө гэдэг юм. Засгийн газар ОТ төслийг ялангуяа гүний уурхайн бүтээн байгуулалтыг явуулья гэдэг шийдвэр, тохироогоо хийчихсэн. Санхүүжилт үүний үндсэнд бий болж ажил нь явж байна. Өөрийн гэсэн стандарт, дэг журмаараа урагшилж байна. Хяналтын байгууллагууд нь хяналтаа тавьж буй. Тиймээс үүнийг одоо хэн дуртай нь зогсоодог үе өнгөрсөн. Бизнесийг бизнесээр нь үлдээж улс төрөөс ангид байлгая гэдэг шийдэл гарсан. Ингэвэл хурдан үр ашигтай, олон компаниудтай хамтарч ажиллана. Өнөөдөр 1000 компанитай бизнес хийж байна. Үүнийг илүү олон болгохоор ажиллаж байна. Бид энэ удаад нэг зүйлийг хариуцлагатай хийж байгаа. Өмнө нь гаргасан алдаагаа давтахгүй шүү гэдэг дээр. Өнөөдөр гүний уурхайн бүтээн байгуулалтад зургаан тэрбум ам.доллар зарцуулна. Үүнээс нэг ►

**Засгийн газар
ОТ төслийг
ялангуяа гүний
уурхайн бүтээн
байгуулалтыг
явуулья гэдэг
шийдвэр,
тохироогоо
хийчихсэн.**

► ам.доллар тутмын 80 центийг ОТ-той хамтарч байгаа монгол компаниудад зарцуулах төлөвлөгөө гаргаад явж байна. Ингэж санхүүжилтийн мөнгөний дийлэнхийг нь Монголд үлдээх гэж оролдоно. Энэ бүхэн өмнөх алдаагаа давтахгүй гэдэгтэй холбоотой. Өмнө нь буруу тооцоо хийгээд яараад зардлын хэтрэлт бий болсон. Одоо ийм зүйлээс болж асуудал үүсгэхгүй, илүү зардал гаргахгүй гэдэг дээр нарийн ажиллаж байна. Энэ бүх төсвийг шинэчилж баталж гаргахын тулд бүх газраас нарийн зардлын тооцоог ирүүлж, нэтгэж хийхэд 200 хүн өдөр шөнөгүй ажиллаж байна. Том ажлыг бараа сүрийг нь харж байгаад төстэй бусадтай харьцуулаад дуурайгаад хийчихэж болохгүй л дээ.

-Уул уурхайн салбарт эерэг хандлага харагдаж эхэллээ. Гэвч баярлахад хэт эрт юм биш үү?

-Нөхцөл сайжирч байгаа бол сайн л биз дээ. Гэхдээ та зардал багатайгаар бизнесийн үйл ажиллагааг явуулж чадаж байвал зах зээлийн эрсдэлээс хамаарах бага боломж бий болгоно. Боломж л байвал бүсээ чангалаад нарийн тооцоотой байх хэрэгтэй. Үгүй аваас одоо гайгүй болчихлоо гээд хэрэгжүүлж байсан аргаа хаячихвал эцэстээ том эрсдэлд хүрнэ. Хамгийн бага зардалтайгаар үйл ажиллагаа явуулснаар өрсөлдөх чадвараа хадгалж, өөрчлөлтүүд хийн, үүнд таарсан санхүүжилтийг босгоод явна.

-"Mongolian Mining Corporation"-ийн зээлээ цагт нь төлж чадахгүйгээ мэдэгдсэн нөхцөл байдлыг та яаж харж байна вэ?

-Аливаа компани санхүүгийн менежментийг хийхдээ нарийн тооцоотой хийх ёстой. Өнөөдөр нүүрсний зах зээл дээр зөвхөн ММС биш бидний мэддэг Пийбоди хүртэл хүнд байдалд ороод бусад нүүрсний компани нааш цааш зарагдсан байдалтай байна. Монголд ММС ийм байдалд орчихсоноо ил зарласан учраас л бид ингээд байна. Тэд ийм нөхцөлд ахиад л зардлаа багасгах тал дээр ажиллаад зээлдээ бүтцийн шийдэл гаргаад явж байгаа. Монголын компани хүнд байдалд орж байгаа нь сайн биш. Ард нь олон мянган ажлын байр бий. Нөгөө талд туулах ёстой замыг туулаад хүнд байдлаас гарч байж л үйл ажиллагаагаа сэргээнэ. Хийх ёстойгоо хийж л байгаа байх.

-Та саяхан Торонто руу хөрөнгө оруулагчдын томоохон уулзалтад яваад ирсэн. Гадныхны хандлага ямар байна вэ?

-Хүн гоё ярьсанд биш, хэлснээ хийж байгаа эсэхт л итгэнэ. Оюутолгой явж байгааг тэд мэдэж байгаа. За ямартай ч Оюутолгой нь явах юм байна, араас нь Гацуурт, Хан ресурс шийдэгдлээ гэж харж буй. Ер нь бол Монголын үндсэн өгөгдлүүд өөрчлөгдөөгүй. Дэлхийн хамгийн хурдан өсөж

байгаа эдийн засгийн бүст, хамгийн том эдийн засаг болох гэж буй улсын хажууд байрладаг, Хятадын өсөлтөд шаардлагатай бүтээгдэхүүнийг хамгийн хямдаар үйлдвэрлэж болох нөхцлийг агуулсан, ардчилсан улс хэвээрээ гэх мэт.

-Сонгуулийн дараа өмнөх сонгуулиуд шиг бодлогын өөрчлөлт хийгдэх магадлал хэр өндөр гэж тооцож байна вэ?

-Нэгэнт л ардчилсан улс юм чинь сонгууль болдгоороо болно. Өмнөх тохиолдлуудад сонгууль бүрийн дараа бодлого өөрчлөгдөж байсан. Хүмүүс тэрийг эрсдэл гэж харж байгаа. Бид гадныхан руу гүйж очоод, энэ сонгуулийн дараа л жинхнээсээ арай өөр болно гэвэл одоо бол хэн ч итгэхгүй. Харин сонгуулийн дараа үнэхээр нөхцөл өөрчлөгдөлгүй, тогтвортой байсан тохиолдолд л



итгэнэ. Оюутолгойн тухайд бид хэдэн жил маргаад, маргаашаас л асуудалгүй болно гээд зөндөө хэлж явсан. Тэгээд болохгүй байсаар байгаад хүнд нөхцөлд хоёр тал хоёул орсон. Тэгээд эргээд гарахдаа нарийн нөхцлүүдээ тохироод, итгэл ч нэмэгдэж, авах юмаа ч нэмэгдүүлсэн. Үүнийг ярихгүй л байгаа болохоос, бид ямар өгөөж байгааг тооцоод үүнээс хойш ингэж тооцдог болой гэж тохироод таван тэрбум ам.долларыг илүү авахаар тохироод явж байгаа. Тохирсоноороо хоёр тал ажлаа хийгээд л байвал итгэл улам нэмэгдэнэ.

Хүний эрх, өмчийн эрх гээд хоёр үндсэн эрх байна. Хүний эрх талдаа бид харьцангуй өндөр үзүүлэлттэй орнуудын нэг. Нөгөө талдаа өмчийн эрхийн асуудал байна. Хувь хүн өмчтэй байна, үүнийг төр хамгаалдаг байх. Тэр эрхийг хэзээ ч хаана ч орхигдуулахгүй хамгаалдаг байх тал дээр л илүү ажиллах хэрэг байна. Тэгвэл манай эдийн засаг илүү эрүүл явна. Хэн ч сонгуульд ялсан нэг их ялгаа гараад байхгүй. Бодлогын өөрчлөлт бол өмчийн эрхийн тухай дутуу ойлгосноос болдог. ■

MON  **LANS**
since 1990



ADDRESS: Sukhbaatar_district, 9 khoroo, Altain street 8-236,
Ulaanbaatar city, Mongolia

FACEBOOK: Mon Lans

SKYPE: Mon-lans

MOBILE: 976-99997706, 99017706, 99097706

EMAIL: monlans2000@yahoo.com
monlansllc@gmail.com

VIBER: 976-99997706

FAX: 976-350493

Өрийн менежмент

Дампуурлын зүг урагшаа

Б.ҮҮРИЙНТУЯА

Сөргөлдөөн эсвэл халдварт өвчний тархалтын улмаас 2013-2015 онд байгалийн баялагт суурилсан эдийн засаг нь огцом унасан хөгжиж буй орнуудад Өмнөд Судан, Сиерра Леон, Украин багтаж байна. Гэтэл тэдний багтаж буй тус жагсаалтад Монгол Улс “тууж” яваа нь хачирхалтай. Дайнгүй, тахалгүй тэгсэн атлаа дээрх орнуудтай мөр зэргэцээд буруу жагсаалтад орчихсон байх юм. Гадаад харилцааны сайд асан Г.Занданшатарын тодорхойлсноор эдийн засаг вирустсэн аж. Улсаа хүний бие гэж бодвол эдийн засаг хавдараар өвчилж,


хавдарын эс нь бусад салбарт тархаад эхэлчихэж. Ийм гээд аваад үзвэл эбола нүүрэлсэн Сиерра Леонтай адилтгаж болох юм. Дэлхийн банк энэ жилийн Монголын эдийн засгийн өсөлтийг 0.8 хувь болтол бууруулан таамагласан. Гэтэл хоёр жилийн өмнө 2016 оны өсөлтийг 7.7 хувь гэж байсан. Wall Street Journal-д өнгөрсөн онд Монгол Улсад орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт тун бага байсныг харуулахын зэрэгцээ гадаадын нийт өр 20 тэрбум ам.доллар давсан байгааг онцлоод манайхыг алдагдсан боломжуудын орон гэсэн байгаа юм. Эдийн засаг хөрөнгө

оруулалт, уул уурхайтайгаа таг болов. Тасралтгүй өсөж байгаа нь өр, авлига. 2015 оны байдлаар манай улсын гадаад өрийн хэмжээ сүүлийн зургаан жилийн хугацаанд 10 дахин нэмэгдсэн, Засгийн газрын өр 3.65 тэрбум ам.доллар болж өссөн. Энэ нь 2009 оны гадаад өрийн хэмжээнээс хоёр дахин нэмэгдсэн үзүүлэлт. Өнөөдрийн тоон баримтаас үзвэл манай улсын гадаад өрийн нийт хэмжээ 22 тэрбум ам.долларт дөхөх бөгөөд ирэх оноос эхлээд төлөх ёстой зээлийн эргэн төлөлтүүд биднийг амдаад зогсож байна. Гэтэл Монгол Улс өрийн хэмжээгээ өсгөсөөр байгаа нь сэтгэл зовинох үндэслэл яах аргагүй мөн гэдгийг манай улсад 2014, 2015 онд зочилсон Германы эдийн засагч Ханс Вернер Зинн болон Биатрис Ди Мауро нийгмийн уншиж, судалдаг хэсэг төлөөлөгчдөд илтгэл тавих үеэрээ сануулж байлаа. Тэгсэн саяхан Ерөнхий сайд Ч.Сайханбилэг Засгийн газар Credit Suisse банкнаас 250 сая ам.долларын зээл авсан гэж мэдээлэв. “Энэ бол зээл. Өр биш” хэмээн Сангийн сайд Б.Болор онцлоод төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор аваагүй гэсээр буй. Сангийн сайдын хэлж байгаагаар уг 250 сая ам.доллараар дотоодын өндөр хүүтэй бондод санхүүжилт хийх юм байна. Энэ бол амь тариа. Араас нь урт хугацааны эмчилгээ шаардлагатай.


Буруу тал

Дэлхийн таваарын зах зээл огцом унасан нь Монголын эдийн засагт хүчтэй нөлөөлж байна


Гадаадын шууд хөрөнгө оруулалты дотогш чиглэх нийт урсгал



Гадаадын нийт өр



ДНБ-ий жилийн өсөлтийн таамаг



Эх сурвалж: Монголбанк Bank of Mongolia (ГШХ, Өр); Дэлхийн банк (ДНБ)

THE WALL STREET JOURNAL

Монгол ба Мозамбик, Нигер тэгээд Латин Америк

Азийн орон атлаа адилтгах гэхээр Африкийн орнуудтай жагсах болсон Монголын эдийн засгийн үзүүлэлтүүд улам муудаж байна. Тодруулбал, ДНБ-ийг гадаад өртэй харьцуулсан судалгаагаар Монгол, Мозамбик хоёр зуу зай холбон тэргүүлдэг. Авлигын түвшнөөр бол Нигертэй ахан, дүүс. Дампуурлын магадлалаар дефолт болох хамгийн өндөр эрсдэлтэй 14 орны наймдугаарт эрэмбэлэгдэж байгаа юм. Энэ утгаараа Аргентин, Чилитэй адилхан.

Эргэн төлөх чадавхтай бол гадаадаас авсан гуйлгыг зээл гэнэ. Харин өгөөжгүйгээр зарцуулвал тэр өр болж хувирна. Уул уурхайд суурилан эдийн засаг тэлж байхад баруун, солгойгүй цацаж ирсэн нь өнөөгийн нөхцөлд хүргэсэн гэдэг. Тэр үед Баялгийн сан байгуулаад, орж ирсэн мөнгөө хуримтуулсан бол гэж

▶ халаглах хүн олон. Гэвч ярьж байсан ч хийгээгүй учраас өнөөдөр “Хэрвээ” гэх эрх бидэнд алга. Түүнчлэн өгөөжгүй үрсэний нэг жишээ бол төсвийн алдаглаа валютаар нөхөх явдал. Өрийг өрөөр дарах нь ухаалаг алхам биш гэдгийг дээр дурьдсан эдийн засагч Биатрис Ди Мауро зөвлөсөн. Судлаач Л.Гангэрэл ч мөн хамгийн явцгүй шийдэл гэж дүгнэж буй. Тэрбээр “Өрийг өрөөр дарна гэдэг өмнөх хүүгээс илүү өндөр хүүгээр зээл авч байна гэсэн үг. Ингээд ам.долларыг төгрөгтэй харьцуулахад өндөр үнэтэй тусаад байна. Тэгээд төгрөгөөрөө өрөө шилжүүлээд бодохоор өр хамаагүй ихэсч байгаа юм” гэлээ. Түүнчлэн Засгийн газар өр барагдуулах асуудалд ямар ч тодорхой төлөвлөгөөгүй явж байгааг Л.Гангэрэл шүүмжилсэн.

Өнөөдөр зөвхөн төрийн өрийг онцолж байна. Гэтэл улсын нийт өрийн түвшинд хувийн хэвшил ямар хэмжээнд хувь үзүүлж байгааг тэр бүр ярихгүй байгаа юм. Хувийн хэвшилд зүтгэгчдийн зарим нь гаднаас зээлсэн мөнгө өр болох эрсдэлийг хувийн хэвшил өөрөө үүрдэг тул асуудал болгож дэвэргэх шаардлагагүй гэж үздэг. Харин улс өрөнд баригдахад хувийн хэвшлийн гадаад өрийн асуудал тун аюултай нөлөө үзүүлдэг аж. Монголдоо том Mongolian Mining Corporation зээлээ төлж чадахгүй болж, улмаар дампуурах нь тодорхой гэсэн мэдээлэл гарах болсон. Коксжих нүүрсний үйлдвэрлэлээрээ Монголдоо тэргүүлдэг тус компанийн зээлжих зэрэглэлийг Moody's хагас жил орчмын өмнө бууруулахдаа ирэх жил дампуурах магадлал өндөр хэмээн үзсэн байгаа юм. Энэ мэтээр улсад чухал нөлөөтэй компаниуд дампуурвал ямар хохирол учирдагийг 1970, 1980-аад онд дампуурлаа зарласан Латин Америкийн орнуудын жишээ харуулдаг. Латин Америкийн орнууд болоод Грек, Испанийн өрийн хямрал хувийн хэвшлийн гадаад өрийг чухалчилан анхаарч, шаардлагатай бол хязгаарлах хэрэгтэй гэдгийг харуулсан. Хэдийгээр Capital Control эдийн засагтаа сөрөг нөлөө үзүүлэх нь бий ч хувийн хэвшлийн гадаад өрийн менежмент зайлшгүй байх ёстой бодлогын зохицуулалт аж. Харин манайд энэ асуудлыг анхааралдаа авч буй нь ховор. Хувийн хэвшлийн өрийн хэмжээг судалсан бодит тоо байдаггүй бөгөөд өнөөдөр бидний мэдэх өрийн үзүүлэлтүүд

бүрэн бус гэдгийг Гадаад хэргийн сайд асан Г.Занданшатар манай сэтгүүлд өгсөн нэгэн ярилцлагадаа дурьдсан. Тодруулбал, дэлхийн томоохон судалгааны байгууллагуудын гаргасан тооцоолол манайд мэдээлдэг тоотой зөрдөг, өрийн таазыг тодорхойлох аргачлал өнөөдрийн үнэ цэнээр тогтоогдож байна. Түүнчлэн өр нэмэгдэхэд хамгийн их нөлөөлж буй зүйл бол хууль эрх зүйн муу тогтолцоо. Хууль гаргаад зогсох биш хэрэгжилт чухал гэдгийг гадаад, дотоодын эдийн засагчид амаа чилгэл ярьдаг. Гэвч зээлээ өр болгох асуудал хэдхэн хүний шийдвэрээр явах болсон нь дампуулын зүг урагшаа гэж буйтай ижил ойлгогдож байгаа юм. Үүгээр ч зогсохгүй валютын дотогшлох урсгал хумигдсаар байхад гадагшлах суваг улам өргөжсөөр байна.

Таваарын ханш мөчлөгийн оргилдоо байхад манай улсын Засгийн газар бонд гаргаж байлаа. Гэтэл хөгжиж буй зах зээлүүд өдгөө тэвдэж байхад Монгол хэдийнэ хямарчихсан явна. Pacific Investment Management Co., Schro-

der Investment Management тэргүүтэй дэлхийн томоохон сангууд Монголд хөрөнгө оруулж байсан. Гэвч өнөөдөр гадныхан оруулсан хувиа аваад хурдан арилах тухай бодож буй. Өнгөрсөн хугацаанд Засгийн газрын бондын өгөөж 9.4 хувь болж өссөн нь Ази тивдээ хамгийн муу үзүүлэлт болсон. Сүүлийн үеийн мэдээллээр бондын өгөөж найман хувьд хүрч буурчээ.

Хятадын эдийн засгийн удаашрал, таваарын ханшийн уналт манай эдийн засаг ийн уруудахад нөлөө үзүүлсэн ч өнөөдрийн хэмжээнд хүрэхэд хамгийн их нөлөөтэй нь бид өөрсдөө. Өнөөдөр цадаж байвал маргааш өлсөх хамаагүй гэсэн сэтгэлгээгээр хандаж олж ирсэнээ засаг нь тараахад ард иргэд нь ч хадгалах бус ходоод руугаа хийчихсэн. Дэлхийн банкны мэдээлснээр эдийн засаг буурахын хэрээр монголчуудын амьдрал ядуурлын түвшин тодорхойлох доод цэг рүү уруудаж байна. Ажилгүйдэл өсч 2015 оны сүүлийн улиралд 8.3 хувь болжээ. ■



Санхүүгийн зах зээл

Мөнгөний дэд бүтэц

Б.ЭНХ

Нэг талаас банкны салбар идэвхтэй хөгжөөд байгаа ч нөгөө талаас хөрөнгийн зах зээл, даатгалын салбар нь эрийн цээнд хүрэх яагаа ч үгүй явна. Зарим хөгжиж буй оронтой харьцуулахад Монголын банкны салбар илүү ч өндөр үзүүлэлт, хөгжилтэй яваа. Иргэдийн санхүүгийн боловсролыг

харсан ч тэр банкаар хэрхэн үйлчлүүлж, мөн ашиглахаа харьцангуй сайн мэдэж байхад даатгуулах, хувьцаа авах, зарахын үр ашгийг төдийлэн сайн ухаарч энэ зүгт доривтойхон хөдөлж өгдөггүй. Улсдаа хэдэн зуун сая ам.доллараар тоологдох татварын орлого оруулж, олон зуун мянган хүнийг ажиллуулдаг ▶

► өнөөгийн акул компаниуд нь /Tesla, Apple гэх мэт/ бүгд санхүүгийн зах зээлийн үр нөлөө юм. Өөрөөр хэлбэл, тэд бизнесээ санхүүжүүлэх боломж, сонголтоор хангагдаж байсанд оршиж буй. “Санхүүгийн зах зээл нь мөнгөний дэд бүтэц. Мөнгө чөлөөтэй, зөв урсаж байж хөгжил ирдэгийг дэлхийн түүх нотолно” хэмээн эдийн засагч Ө.Ганзориг хэлсэн байдаг.

Олон улсын хөрөнгө оруулалт татарч байгаад Хятадыг тойрсон бүс нутгууд болон Өмнөд Африк, Хойд Америкийн эдийн засгууд буюу уул уурхайтай холбоотой эдийн засгууд нэрвэгдэж байна. Гэхдээ нөгөө талаас Америкийн эдийн засаг сэргэж, Европ араас нь сайжран явж байна. “Азийн зуун” ирж байна гээд байсан ч одоо илүү эрсдэл багатай хөгжингүй орнууд руу хөрөнгө оруулалт чиглэх хандлага болж хувирч байна. АНУ бодлогын хүүгээ нэмвэл тэр улсад хөрөнгө оруулах илүү ашигтай болно гэсэн үг. Тэгэхээр хөрөнгө оруулалтыг татах өрсөлдөөн улам ширүүснэ гэж санхүүгийн мэргэжилтнүүд хэлж байна. Харьцангуй тогтмол өсөлттэй эдийн засаг руу шилжиж байгаа мөн гадаадын хөрөнгө оруулалт татарч буй энэ нөхцөлд аль болох дотооддоо хийж бүтээх хэрэгцээ байна. Ингэхийн тулд асар их санхүүжилт хэрэгтэй. Бид зөвхөн төгрөг хэвлэдэг, валют хэвлэдэггүй. Тиймээс гадны хөрөнгө оруулалт хэрэгтэй. Үүнтэй зэрэгцээд бид дотоодын санхүүгийн боломжуудаа чанаржуулах, олшруулах. Улмаар эдийн засгийн өсөлтийг хүртээмжтэй болгох, баялгийн шударга хуваарилалтыг бий болгоё гэвэл санхүүгийн системийн бусад салбарыг хөгжүүлэх нь зайлж боломгүй зам.

Банкны салбар

Банкуудын олгосон зээлийн хэмжээ 2015 онд өмнөх оны мөн үеэс таван хувиар буурчээ. Хугацаа хэтэрсэн зээл 1.6 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс даруй 2.6 дахин өссөн байна. Харилцах хадгаламж нөгөө талаас буурсан. Муу зээл ийнхүү нэмэгдэж байгаа нь ихэвчлэн уул уурхай, барилгын салбараас улбаатай. Зээлийн түүх, үл хөдлөх хөрөнгө дээр голдуу тулгуурлан зээл өгдөг банкууд өдгөө зээлээ ерөнхийдөө хүмий хандлагатай байна. Учир нь үл хөдлөх хөрөнгийн үнэ тасралтгүй

буурсаар. Эдийн засаг хүндэрсэн энэ цаг үед банкууд үндсэндээ хаалгаа хаадаг зарчимтай. Зээлээ зогсоож, бодлогуудаа чангатгана, мөн барьцаа хөрөнгийн үнэлгээг илүү буруулна. Нэг талаас зээлийн олдоц багасаад, зээл байхгүй болохоор бизнесийн үйл ажиллагаа саарч эдийн засаг хумигдаж байгаа. Зарим банк энэхүү эдийн засгийн нөхцлийг урьдчилж таамаглан хаширлаж, найман хувийн хүүтэй зээлийн хөтөлбөр эхлэхээс өмнө барьж байсан үл хөдлөх хөрөнгийн үнэлгээгээ орон сууцны зах зээл тэсэрч, үнэ “огшиж” байхад ч дээшлүүлэлгүй хэвэнд нь барьсан нь иргэдийн дургүйцлийг хүргэж байлаа. Харин үнэ буурсан энэ үед эрсдэлийн зөв тооцоо байсныг харуулж буй. Гэвч таван хувийн хүүтэй орон сууцны зээлийг баталгаажуулсны ачаар энэ төрлийн зээл тоогоо нэмэх бололтой. Мөн Оюутолгойн төслийн хоёрдугаар шатны санхүүжилт банкны салбарт бодитой түлхэц өгч чадах гол хөшүүрэг гэж салбарын мэргэжилтнүүд харж байна.

Банкны салбарт бонд хэлбэрээр дэлхийн олон хөрөнгө оруулагчдыг хамруулан хөрөнгө оруулалт татах үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимжсэн. Саяхан ХХБ гэхэд хагас тэрбум ам.долларын бонд гаргаж, хаврын энэ тарчиг цагт оруулаад ирлээ. Гэхдээ энэхүү санхүүжилтийг урьдын жишгээр, үйлчилгээ, худалдааны салбар луу богино хугацаатайгаар түлхүү өгвөл, урт хугацааны санхүүжилт шаардлагатай үйлдвэрлэлийнхэнд нэг их хүртээл болохгүй. Банкуудын хувьд үндэсний үйлдвэрлэлийг дэмжинэ гэдэг ч ашиг нь урт хугацаанд бий болдог бизнесүүд дэх эрсдэлээс эмээгээд барагтаа бол хөдөлдөггүй. Угаас нэг жилийн хугацаатай хадгаламж татчихаад, 5 жилийн хугацаатай зээл өгөх нь бизнесийн загвар талаасаа утгагүй. Гэвч бондын мөнгө оруулж ирж буй тохиолдолд нөхцлийн өгөгдөл өөрчлөгдөж болох талтай.

“Банкуудын хувьд төлөвших хэрэгтэй, сурах зүйл их байна. Бидний хувьд худалдаа, үйлчилгээ, шууд олборлоод зардаг уул уурхайн хэсгийг санхүүжүүлээд сурчихсан. Энэ нь илүү эрсдэл багатай. Одоо улс орны хэмжээнд шаардагтаа байгаа илүү урт хугацаанд өгөөжөө өгдөг, арай илүү эрсдэлтэй төсөл, үйлдвэрлэл, дэд бүтцийн санхүүжилтийг олгож сурах

хэрэгтэй” хэмээн ХХБ-ны гүйцэтгэх захирал О.Орхон хэлж байна.

Мөн ТОС гэж хөтөлбөрийг банкууд хэрэгжүүлээд эхэллээ. Нийгэм Байгаль орчинд ээлтэй, ногоон технологийн хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлэх зорилготой. Энэ нь нэг талаас Төвбанк, арилжааны банкууд болон олон улсын байгууллагууд хамтраад санхүүгийн тогтолцоог шинэ шатанд гаргах ажлыг хийж байгаа хэрэг гэж Орхон захирал тайлбарлаж байна.

Хөрөнгийн зах зээл

“Эдийн засаг хүндрээд компаниуд банкны зээлийн босгыг давахааргүй хэмжээнд ирчихлээ. Тэгэхээр хоёрдугаар сонголтыг хайж байна. Тэр нь хөрөнгийн зах. Энэ зах дээр бонд ба хувьцаа гэсэн хоёр сонголт байгаа. Бонд гэхээр сая “Эрчим бонд” гарлаа. Хувьцаа гэвэл “Монгол шуудан” гарсан. Энэ зах зээл рүү хүссэн, хүсээгүй анхаарлаа хандуулах эдийн засгийн суурь шалтгаан байна” хэмээн Гаули үнэт цаасны компанийн шинжээч Г.Мөнх-Эрдэнэ хэлж байна.

Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс 12.5 хувиар буурчээ. Ийнхүү хэмжээ буурахад голчлон уул уурхай, барилга угсралт болон үйлчилгээний салбарын компаниудын хувьцааны ханш буурсан нь нөлөөлжээ. Харин энэхүү бууралтын эсрэг үйлдвэрлэл, хөдөө аж ахуй болон үл хөдлөх хөрөнгийн чиглэлийн компаниудын зах зээлийн үнэлгээ өсөлттэй гарсныг СЗХ-ны Санхүүгийн зах зээлийн тоймд бичжээ. Мөн уг тоймоос 2015 оны жилийн эцсийн ТОП-20 индексийн үзүүлэлт 13.1 хувиар буурсныг харж болохоор байна. Гэхдээ тус тоймыг бэлтгэсэн тайлант хугацаанд олон нийтэд “Бинсэ” “БиДиСек”, “Эрчим инженеринг”, “МИК Холдинг” анхдагч зах зээлээр хувьцаагаа арилжсан нь 2008 оноос хойших хугацаанд олон нийтэд үнэт цаасаа санал болгон гаргасан хамгийн өндөр үзүүлэлт болсныг тайланд онцолжээ. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн зах зээлийн дэлгүүрийн лангуу чамгүй бараатай байлаа. Үүний зэрэгцээ богино хугацаатай Засгийн газрын үнэт цаасыг иргэд авах сонирхол өндөр байсан нь статистик мэдээллээс харагдаж байна. Гэхдээ мэдээж энэ хангалттай биш. Нөгөө ►

▶ талаас хөрөнгийн захын гол худалдан авагчид болох хөрөнгө оруулалтын сангууд байхгүй байлаа. Гэхдээ одоогоор хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсаны үрээр долоон компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл аваад байгаа. “Гаднын хөгжихсөн зах зээл дээр байгаа оролцогчидтой харьцуулаад үзэхэд манайд тэдгээр оролцогчдын ихэнх нь байна. Гэтэл нэг л урагшилж өгөхгүй байгаа нь тэднийг зангиддаг хөгжлийн институци байхгүй байгаад оршиж байна” гэж Мөнх-Эрдэнэ хэлж байна.

“Монгол шуудан” ТӨХК-ийн 34 хувийг Монголын хөрөнгийн биржээр хувьчлахад худалдан авах захиалгын дүн хоёр дахин давсан. Хувьчлахаар жагсаалтад оруулсан 22 компанийн зөвхөн есийг нь л биржээр дамжуулан хувьчлахаар тогтоосон байгаад салбарын оролцогчид дурамжхан байна. Хариуцаж буй төрийн албаныхан сайныгаа биржээр, тааруугаа өөр арга замаар хувьчлана гэж буй. Харин хөрөнгийн захын зарим мэргэжилтэн сайн, муу хамаагүй бүх компанийг биржээр хувьчлах нь шударга гэж үзэж байгаа юм.

Хөрөнгийн захыг сонирхож буй гадныхны тоо олширсон ч оролцоон дахь идэвх сул хэвээр байгаа. Өнгөрсөн жил Оюутолгойн хоёр дахь шатны санхүүжилт тодорхой болоход ТОП 20 индекс 25-26 хувиар өссөн. 2009 онд анхны гэрээ зурагдахад мөн ингэж өссөн байдаг. Брокер дилерийн компаниудын зүгээс одоо сонгууль болоод мөн Оюутолгойн санхүүжилт орж ирээд бүтээн байгуулалт бодитоор яваад ирэхээр гаднынхан хувьцаанд хөрөнгө оруулалт хийнэ гэж итгэлтэй хэлж байна. Оюутолгой бодитоор яваад эхлэх үед сайн үзүүлэлттэй компаниуд IPO хийвэл мөнгө босгох боломж мөн байна гэх. Таван жилийн өмнөхтэй харьцуулбал Монголын хөрөнгийн захын хууль эрх зүй харьцангуй сайжирсан, боломжийн гэдэг үнэлгээ аваад буй. Нээгдсэн боломжийг ийнхүү дотоодын иргэд төдийлэн сайн ашиглахгүй байгааг таниулах сурталчлах, ойлгуулах энэ талын мэдлэгийг нэмэгдүүлэх хүртээмжтэй арга хэлбэр, ажил дутуу байгаагай мэргэжилтнүүд холбож байна.

Даатгалын салбар

Ердийн даатгалын зах зээлд 15 компани байдаг. Тэгвэл салбарынхаа 51.5 хувийг таван компани нийлээд эзэлж байна. Энэ нь ердийн даатгалын салбарын өрсөлдөөний хэлбэр нь олигополь /цөөн компаниудын дунд өрсөлдөөн өрнөдөг/ зах зээлийн шинжийг агуулсан байна. Улмаар үнийн өрсөлдөөн өндөр байгааг илтгэж байгаа тул цаашид даатгалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн үнийн зохицуулалтыг бий болгох, хохирол нөхөлтийн болон зардлын харьцааны тооцооллыг шинэчлэх шаардлагатай байна хэмээн СЗХ-ны Санхүүгийн зах зээлийн тайланд бичжээ. “Өдгөө манай улсын даатгалын компаниуд олсон 100 төгрөг тутамдаа 150 төгрөг буцаагаад алдаж байгаа. Эцэстээ энэ нь компаниуд ашиг бус өсөлтийг чухалчилж буйг илтгэж байна” хэмээн “Тэнгэр Даатгал” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ойбек Н.Халилов Блүүмберг Монголиа телевизэд өгсөн ярилцлагадаа хэлсэн.

Өнгөрсөн онд ердийн болон урт хугацааны даатгалын 17 компани 23 төрлийн бүтээгдэхүүнийг иргэд, аж ахуйн нэгжүүдэд санал болгосноор өссөн дүнгээр 2.1 сая гаруй ширхэг даатгалын гэрээ байгуулагджээ. Гэхдээ манай даатгалын компаниуд дийлэнх нь гаднын даатгалын компаниудын бүтээгдэхүүнийг Монголд зуучлан хүргэх замаар “дамжуулан өнгөрөөгч”-ийн үүрэг гүйцэтгэх хандлагатай байгааг дурьдах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, үндсэндээ, тэд өөрсдөөсөө даатгалын бүтээгдэхүүн гаргаж өгөлгүй, бусдынхыг зарж өгөөд хувиа аваад сууж байна гэсэн үг.

Өнгөрсөн онд хийгдсэн том ажлуудын нэг нь Хөдөө аж ахуйн давхар даатгалын компани Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эхлүүлсэн нь юм. Тус компанийн нийт хөрөнгийн дүн 26.1 тэрбум төгрөгт хүрээд байна. Үндэсний давхар даатгалын компани үйл ажиллагаа эрхэлснээр давхар даатгалын чиглэлээр гадагш шилжүүлж буй хураамжийн орлогыг дотооддоо төвлөрүүлэх боломж тодорхой хэмжээнд бүрдэнэ гэж үзэж буй.

Ойбек Н.Халилов даатгалын салбарын хувьд банкны салбарыг нэг боломж нь гэж харж байна. Банкны салбарыг даатгалын бүтээгдэхүүнийг тараах, танилцуулах суваг болгон

ашиглах боломжтой. Гэхдээ албан хүчээр даатгалын бүтээгдэхүүн тулгах бус зөв замаар бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх нь зүйтэйг мөн тэрбээр санууллаа.

Даатгалын компаниудын нөөц сангийн хөрөнгө оруулалтыг өмнөх онтой харьцуулахад тэдний банкны хадгаламж нь 62.5 хувиар өссөн. Мөн “Монголын хөрөнгийн бирж дээр арилжигдсан “Эрчим бонд”-ын 28 хувийг даатгалын компани эзэмшиж байсан. Даатгагдсан гэдэг утгаараа олонд зарлахдаа ямар ч эрсдэлгүй гэж танилцуулж байлаа. Энэ бол Монголдоо даатгал, хөрөнгө зах хоёрыг холбосон жишиг бүтээгдэхүүн. Сүүлийн жилүүдэд олон улсын давхар даатгалын зах зээлд үнэт цаасжуулсан даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ эрчимтэй өссөн ба 2015 оны байдлаар 25 тэрбум ам.долларт хүрчээ.

Цаашид ч даатгалын салбарын эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэн санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээг өсгөх чиглэлээр албан журмын даатгалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг олшруулах, урт хугацааны даатгалыг төрийн бодлогын түвшинд авч, хөгжүүлэх шаардлага үүсээд байна гэж СЗХ тайландаа дүгнэжээ. Гэтэл тээврийн хэрэгсэл, моргейж зэрэг төрлийн бүтээгдэхүүнийг албан журмын даатгалд хамруулж байгаа ч бүгдийг шахам албан журмын болгох нь энэ салбарын хөрвөх чадварт халтайг салбарын мэргэжилтнүүд хэлж байна.

Жолоочийн хариуцлагын даатгалыг албан журмын болгонгуут даатгалын салбар борооны дараах мөөг шиг олон зуучтай /тусгай зөвшөөрөлтэй 35/ болчихсон. Гэтэл тэд ядаж өгч буй даатгалын гэрээт баталгаан дээрээ юу гээд биччихсэн, ямар учиртайг ч тайлбарлаж өгөхгүй нь олонтой. Зах зээл хөгжөөд ирэхээр аяндаа даатгуулагч нь даатгалын компани руу бус эхлээд брокер луу очоод, даатгалаа сонгодог тогтолцоо бий. Тээврийн хэрэгслээ даатгуулаа гэвэл, өөрийн үйлчлүүлдэг брокер луу яриад үнэ асуудаг. Брокер зах зээл дээр байгаа компаниудын санал болгож буй үнүүдийг харьцуулаад даатгуулагчид санал болгож сонгуулдаг. “Монгол улсын даатгалын салбар даатгагч төвтэй. Харин олон улсын даатгалын салбарын жишиг хөгжил нь даатгалын зуучлагч төв рүү чиглэсэн байдаг. Даатгалын гэрээ талх авах шиг хялбар биш тул зөв даатгал худалдаж авахад даатгалын зуучлагч ▶

▶ “инновацийг дэмжье гэж байгаа бол төрийн бодлого зөвхөн монголын нөхцөлд тааруулсан байж болохгүй” гэсэн юм. Зах зээл нь жижиг учир дотоодоос олох ашиг их биш, дэлхийн зах зээлд гарахад өрсөлдөх чадваргүй болчихно гэж тэр үзэж байгаа бөгөөд дэлхийн стандартад нийцсэн “бүтээл” гаргах, түүнд туслах чиглэлд бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй хэмээсэн.

Гэхдээ тэр бүтээл нь заавал ямар нэгэн төхөөрөмж, програм хангамж, эм тариа байх албагүй. Хэн нэгний нээлт, оюуны өмчийн эрх нь их хэмжээний мөнгөн баялгийг эзэндээ олж өгсөн жишээ олон. Монгол эрдэмтэд ч жилд дунджаар 200 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг оюуны өмчөөр баталгаажуулдаг байна. Их сургуулиудын дэргэд ажиллаж буй лаборатори, Шинжлэх ухааны парк-мэдээллийн технологийн инкубатор үр ашгаа өгч олон шилдэг “нөү-хау” тэнд боловсрох ёстой. Гэхдээ үүнд тодорхой цаг хугацаа шаардлагатай гэсэн.

Бодлого

Инновацийн талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэг нэг яамнаас нөгөө яамд шилжин гадуурхагдсаар өнөөдөр Боловсрол, соёл шинжлэх ухааны яамд харьяалагдаж байна. Хууль багтагдсанаас хойш дөрвөн жил өнгөрчихөөд байхад “Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогын төсөл”-ийг дөнгөж л Засгийн газраар хэлэлцэх гэж байна.

Уг төсөлд нэлээд нааштай заалтууд тусгагджээ. Инновацийн дэд бүтцийг бий болгож зардлыг төр хариуцна (Технологийн инкубатор, туршилтын үйлдвэр, технологи дамжуулах төв, лицензийн оффис, хурдасгуур компани, инновацийн бүтээгдэхүүнийг зах зээлд арилжаалах үндэсний төв байгуулах). Мөн “Оюуны багтаамж ихтэй, технологи шингэсэн үйлдвэрлэлд хөрөнгө оруулсан, дэвшилтэт технологи нутагшуулсан аж ахуйн нэгжийг татвар, зээлийн бодлогоор тусгайлан дэмжинэ” гэжээ. Үүнээс санхүү, хөрөнгийн асуудалд нэлээд анхаарчээ гэж дүгнэж болохоор байна. Үүний учир нь гарааны бизнесүүдийг олноор бий болгох, үйл ажиллагааг нь дэмжихэд анхаарал чиглүүлжээ. Учир нь инновацийн олон бизнес гараан дээрээ бахарддаг байна. Шинийг санаачлагчдын оюунаас төрсөн бүтээл шууд төгс болчихдоггүй, зах зээлд гаргаж хэрэглэгчдэд таниулж, тэдний

таашаалд нийцүүлж дахин загварчилж, хөгжүүлж, бойжуулах олон үе шатыг давж өрсөлдөөнд шалгарч үлддэг. Үүнд тодорхой зардал, цаг хугацаа зарцуулна. Инноваци, өндөр технологийн газрын мэргэжилтнүүдийн хэлж буйгаар гарааны компаниудыг дэмжихэд дундын сан, венч хөрөнгө оруулалт дутагдаж байгаа гол зүйл аж.

Гэхдээ төр энэ бодлогодоо тууштай үнэнч байгаагүй нь өнгөрсний харамсал. 2012 онд Инновацийн тухай хуулийг батлахдаа венч хөрөнгө оруулалтын компанийн эрх, үүрэг, харилцааг зохицуулахад бүхэл бүтэн бүлэг (тавдугаар бүлэг) зориулсан. Гэвч ганцхан жилийн дараа тус бүлгийн нэг ч заалтыг үлдээгүй хүчингүй болгосон (2013 оны аравдугаар сарын 3-ны өдөр).

Венч хөрөнгө оруулалт гэдэг нь өсөх ирээдүйтэй ч эрсдэлтэй тооцогдож буй компанид хөрөнгө оруулалт хийж үнэ цэнийг нэмэгдүүлэх замаар санхүүгийн хүндрэлээс гаргаж, үйл ажиллагааг тогтворжуулсаны дараа хөрөнгө оруулсан хувьцаагаа зарж илүү их ашиг олдог санхүүгийн арга хэрэгсэл юм. Бүх хөрөнгө оруулалт амжилттай болохгүй ч нэг хоёр нь хөл дээрээ тэнцэхэд л бүх алдагдлаа нөхөж, зарцуулснаасаа хавьгүй их ашиг хийдэг байна.

Зах зээлийн орон зай

Төрд одоо хийх ёстой ажил нь мэдлэгийг баялаг болгогчдыг хөрөнгө

оруулагчидтай холбож өгөх. Үндэсний хөрөнгө оруулагчид ч энэ чиглэлд судалгаа шинжилгээ хийхэд хөрөнгө хүчээ зарцуулж, өөрийн нь баялгийг хэдэн арав, зуу дахин өсгөх “Томас Эдиссон”-ыг хайж олох ёстой юм.

Шууд утгаараа ямар ч боловсруулалт хийлгүйгээр нэгээс нь авч нөгөөд дамлаж зардаг уламжлалт наймааны аргаа өөрчлөх хэрэгтэй. Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал, ногоон эдийн засаг, хүртээмжтэй өсөлт зэрэг зах зээл хаашаа эргэж, шинжлэх ухааны юу руу тэмүүлж байгааг соргогоор мэдэрч шинэ бизнес төлөвлөгөө эхлүүлэх шаардлагатай байна.

Хөдөө аж ахуй, уул уурхайн салбарт шавхагдашгүй нөөц бий гэж олон жил өөр зуураа ярьсан. Гэвч шинжлэх ухаанч дэвшил, зөв менежмент, мэдлэггүйгээр нөөц нөөцөөрөө л үлддэг ажээ. Түүхий эдийн эрэлт тэнгэрт цойлж байсан үед уул уурхайн компаниудад чадварлаг боловсон хүчин хэрэгтэй байсан. Тэд үүний тулд тулд техникийн сургуулиудад сургалтын хэрэгсэл бэлэглэж, оюутнуудад тэтгэлэг олгож, өсөх ирээдүйтэй нэгнийг нь цалинтай дадлагажуулж байв. Үүний адилаар таваар үнэгүйдэж, зардал орлогоосоо давсан энэ үед инновацийн төслүүдэд анхаарлаа хандуулж тэдэнд хөрөнгө оруулах нь зөв гаргалгаа байж болох юм. Эрчим хүч, түлш шатахуун хэмнэх гайхалтай бөгөөд хямд технологиуд эхнээсээ төрөн гарсаар л байгаа. ■

Барилга

Зөнгөөр нь орхичихвол

Г.ОРХОН

Ханаагүй эрэлтийг ханаагүй нийлүүлэлтээр хангана

О н дамжин тэнгэр ширтэн суусан барилгын салбарынханд энэ хавар урьдын шиг тийм ч уян байхгүй нь. Өнгөрсөн оны арваннэгдүгээр сараас хойш цалин гэдгийг умартсан нэгэн байхад, хийсэн ажлынхаа цалинг хэдэн сар дамжин авалгүй суугаа нөгөө нь ч энэ салбарт бий. Учир нь Монголын эдийн засгийн хүндрэл тэдэнд хямрал “бэлэглэсэн”.

Үүнийг нотлох нэг шалтгаан нь өнгөрсөн сард Барилгын бартерын бирж байгуулагдсан явдал байв. Харин яамныхан үүнийг төрөөс аж ахуйн нэгжүүдэд дэмжиж байгаа бодлого гэсэн. Мөнгөн тэмдэгт гарснаас хойш барааг бараагаар сольдог тогтолцоо одоо үед алга болсон ч Монголд энэ нь эрчээ авч эхэлжээ. Үнэндээ энэ салбар дахь мөнгө хямралд түгжигдэж.

Монгол төр Улаанбаатар хотын гэр хороолол руу эргэн харж, тэнд амьдарч байгаа бүх хүн байранд орохоор ▶



Одоогийн байдлаар орон сууц худалдан авах боломжтой 20 гаруй мянган өрх байгаа ч эдгээрээс зээлийн нөхцөл шаардлагыг хангасан, зээл авах боломжтой нь 8700

Фотог Б.Бямба-Очир

► тооцоолж алдаатай бодлого явуулсан гэж шүүмжлэх хүн цөөнгүй. Үүнийг эзнээ хүлээсэн болон хотын булан бүрт харагдах дутуу өрсөн “тетрис тоглоом” шиг саарал барилгууд гэрчилнэ. Угтаа гэр хороололд амьдарч буй бүх хүнд тохилог сууцанд шалавхан нүүгээд орчих хүсэл байлаа ч тэдний санхүүгийн чадамж өнөөх хүслийг нь хазаарлаж буй. Өнгөрсөн оны сүүлээр 18800 гаруй барилгын илүүдэлтэй байсан бол энэ онд 50 хувийн гүйцэтгэлтэй байгаа 26 мянга гаруй айлын орон сууцыг нэмж барих төлөвтэй байна.

Нийлүүлэлт илүүдэлтэй байгаа ч борлуулалт үндсэндээ зогсчихжээ. Учир нь өнөөх ханаагүй эрэлтэд худалдан авах чадвар дутмаг байна. Одоогийн байдлаар орон сууц худалдан авах боломжтой 20 гаруй мянган өрх байгаа ч эдгээрээс зээлийн нөхцөл шаардлагыг хангасан, зээл авах боломжтой нь 8700 Мөн өрхийн сарын орлого буураад байгаа нь иргэдийн худалдан авах чадвар саарахад хүч өгч байгаа юм. Тодруулбал, өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын байдлаар

өрхийн сарын орлого 1.1 сая төгрөг байсан бол энэ оны нэгдүгээр сарын 21-ний байдлаар 848 мянган төгрөг болов.

Орон сууцны зах зээлд дээрх өнөөгийн илүүдэлтэй буй нийлүүлэлтийг Үндэсний бүтээн байгуулалтын корпорацийн ерөнхийлөгч Б.Жүгдэр нийт эдийн засаг мөнгөгүй байгаатай холбон тайлбарлаж байна. Гэсэн ч зарим байршилд орон сууцны үнэ буурахгүй байгааг “Хувийн хөрөнгөөр барилга барьсан компаниуд гадна инженерийн шугам сүлжээгээ өөрсдөө шийдэж, газраа худалдан авч байна. Энэ тохиолдолд барилгын үнэ өснө. Мөн дотор засал, байршил, орчны дэд бүтцийн асуудал зэрэг нь нэлээд сайн шийдэгдсэн барилгууд байна” гэсэн. Түүний хэлснээр барилгын салбар ялангуяа, гүйцэтгэгч компаниудын хувьд хүндрэл чинээндээ тулж.

Барилга, хот байгуулалтын яамныхны тооцоолж буйгаар жилд дунджаар 15900 орчим айлын орон сууц борлуулагдаад явбал эрэлтийг тодорхой хэмжээгээр нийлүүлээд явах боломжтой. /Энэ нь 2015 оны байдлаарх тооцоолол/ Гэтэл сүүлийн хэдэн жилд

жил бүр 7-8 мянган айлын орон сууцны илүүдэл нийлүүлтэй яваа тус салбарыг өнөөгийн хямралаас гаргахын тулд яамны зүгээс борлуулалт талаас нь дэмжих бодлого баримталж байна.

Харин хөндлөнгийн шинжээчид хийгээд, салбарынхны зарим нь эл салбарыг зах зээлийнх нь журмаар явуулах хэрэгтэй төдийгүй төрийн оролцоо хэт их байгаад шиймжлэлтэй ханддаг. “Монголын эдийн засгийн форум” ТББ-ын гүйцэтгэх захирал Б.Лакшми “Моргейжийн зээл олгосонтой холбоотойгоор барилгын компаниудад хөнгөлөлттэй зээл олгох зэргээр бүх талаас нь төр тодорхой хэмжээгээр оролцчихлоо. Энэ зах зээл чөлөөт өрсөлдөөнийх нь гольдролд оруулаагүй, аль аль талаас нь зохицуулалт хийгээд явсан болохоор эрэлт, нийлүүлэлтийн талаас шударга өрсөлдөөн байхгүй болсон” хэмээсэн.

Өнгөрсөн хугацаанд Засгийн газрын зүгээс орон сууцны салбарт дэмжлэг үзүүлснээр барилгын салбарын зээлийн багц нэлээд нэмэгджээ. Оны төгсгөлд л гэхэд нийт зээлийн 41 хувийг үл хөдлөх ►

▶ хөрөнгө, барилгын зээл эзэлж байв. Түүнчлэн эл салбарт төрийн оролцооны тун хэтэрснээс барилгын үнэд хөөсрөл бий болсон гэх нэгэн ч бий. Улаанбаатар хотын зарим хэсэгт Нью Йорк тэргүүтэй хөгжилтэй хотуудын хэмжээнд хүртлээ орон сууцны ам.метрийн үнэ өссөн нь үнэн. Гэтэл Монголын үл хөдлөхийн зах зээл тэр хэмжээнд хөгжсөн үү гэвэл үгүй.


Харин Барилга, хот байгуулалтын яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга Х.Багболд “Бодлого, эрэлт, нийлүүлэлт тэргүүтэй аль аль талаас нь төрийн оролцоо, зохицуулалт байна. Бид одоогийн зарчмуудаа бариад явна. Түрээсийн орон сууцны хөтөлбөрөөс гадна дараа дараагийн борлуулалтын сувгуудаа нэмнэ” гэлээ. Засгийн газрын зүгээс орон сууцны зах зээлийн одоогийн зогсоод буй борлуулалтыг идэвхжүүлэхийн тулд моргейжийн зээлийн хүүг таван хувь болгон бууруулж, хугацааг нь 30 жил болгосон. Мөн түрээсийн орон сууцны

хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэв.

Барилгын салбарт ажиллаж буй компаниудын хувьд моргейжийн зээлийн журамд орох өөрчлөлтийг / таван хувийн хүү/ таатайгаар хүлээж суусан. Гэтэл бодит байдал дээр тэдний хүлээж байсан шиг үр дүн гарсангүй. Орон сууц олноор борлогдсонгүй. Тохилог сууцанд орох хүсэлтэй байгаа 200 орчим мянган өрхийн хэд нь урьдчилгаа төлбөрөө төлж, таван ханатаа, дөрвөн ханатаар солих нь ч бүрхэг хэвээр байна. Чухам таван хувийн хязгаарлалт үүний гол зангилаа. Ипотек дэх Ардчилсан намын тоглолт төгс биелэлээ олоогүй ч тэд амлалтаа дөмөгхөн аргалаадхав. Харин МАН одоог хүртэл урьдчилгааг 10 хувь болгох боломжтой гэдэг байр сууриа хадгалж сууна. Угтаа эл зах зээл сэргэх нь өргөн утгаараа эдийн засаг сайжрахаас хамаарна. Ингэж байж барилгын систем бүрэн ажиллаж эхэлнэ.

Ер нь барилгын салбарыг зах зээлийнх нь зарчмаар явуулсан бол

Сүүлийн хоёр жилд шинээр ашиглалтад орсон орон сууцны борлуулалт ихэвчлэн моргейжийн зээлээр санхүүжигдэж. 2014 онд 23 орчим мянган орон сууц шинээр ашиглалтад орсон бол үүнээс 18 мянга гаруйг нь иргэд шинээр ипотекийн зээлээр авчээ. Харин энэ оны гуравдугаар сарын 15-ны байдлаар 698 иргэн шинээр ипотекийн зээл авсан байна.



өдийд төр эрэлт, нийлүүлэлтийг нь зохицуулах гэж нүүдэл бодон, гашилж суух хэрэг гарахгүй. Сонгуультай уралдан намууд ч шинэ өрөг тавих шаардлагагүй байхсан. Харин иргэд орон сууцны үнэ энэ эрчээрээ уруудаж, хөөс сая хагарч зах зээл дээр бодит үнэ бий болохыг хүлээн сууна. Өнгөрсөн оны сүүлээр орон сууцны дундаж үнэ 2.6 сая төгрөг байсан бол одоо 1.9 сая төгрөг болж буугаад байна. Үл хөдлөхийн шинжээчдийн таамаглаж буйгаар үнэ цаашид ч буух нь. Учир нь нийлүүлэлтийн өнөөгийн эрчийг эрэлт гүйцэхгүй байгаа тул үнэ өсөхгүй байх бодит шалтгаан болж байна. Харин төрийн “сарвуу” оролцвол байдал өөр тийшээ эргэж мэдэх. Гэхдээ салбарынхны зарим нь одоогийн нөхцөлд төрийн дэмжлэгтэйгээр зээл олголт явагдахад л салбарын хөрөнгө эргэж, зах зээл сэргэнэ гэж буй. Ямартай ч таван хувийн хүүтэй ипотекийн зээл олголт байршлын хувьд хязгаарлалттай тул ам.метрийн үнэ өндийхөд хүч өгч чадахгүй нь. Нөгөө талаас, энэ онд барилгын компаниудын хувьд орон сууцны нийлүүлэлт илүүдэлтэй байгаа учир байрны үнийг боломжит хэмжээнд бууруулж мөнгөө чөлөөлөн, эргэлтэд оруулах нь хамгийн чухал шийдвэр болоод буйг судлаачид тэмдэглэж байна. ■

2016 оны байдлаар 253 төслийн 40490 айлын орон сууц зарлагджээ. Байртай болох хүсэлтэй иргэдийн 83 хувь нь орон сууцаа ипотекийн зээлээр авах хүсэлтэй байгаа аж. Зах зээлд зарлагдсан орон сууцны дундаж үнэ хоёр сая гаруй төгрөг. Хамгийн өндөр үнэтэй орон сууц Хан-Уул дүүрэгт 4.8 сая төгрөг байгаа бол хамгийн бага үнэтэй нь Баянзүрх дүүрэгт 1.05 сая төгрөгийн үнэтэй байна.

2015 оны орон сууцны эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг үнийн зэрэглэлээр харьцуулсан судалгааны дүнгээс харахад өрхийн 70 хувь нь 1.8 сая хүртэлх үнэтэй орон сууц худалдаж авах бодит чадамжтай байхад энэ түвшинд нийлүүлэлт 18 хувь байгаа нь худалдан авах чадвар муу байгааг илтгэж байна.

Эх сурвалж: /Барилга Эм Эн ХХК, Судалгааны алба/

Үзэл бодол

Монгол хуульчдын өрсөлдөх чадвар

Б.БАТЗАЯА

(“Ананд адвокатс” хууль зүйн товчооны Ахлах партнер, өмгөөлөгч)



Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд хуульчдын оролцоо өндөр. Хуульчид төрийн болон хувийн хэвшлийн бүхий л салбарт өөр өөрийн мэргэшсэн чиглэлээрээ ажиллаж улсын хөгжлийн гол хөдөлгүүр болдог.

Өнөөгийн нийгэмд хуульчдыг хөгжлийн хөдөлгүүр хэмээн харахаасаа илүүтэй өрөөсгөлөөр харж ойлгох нь их байна. Энэ нь хуульчид бидний өрсөлдөх чадвартай салшгүй холбоотой.

Хууль эрх зүйн болон шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа нь сайшаалтай боловч тухайн шинэтгэлийн цөм болсон хуульчдын өрсөлдөх чадварын асуудлыг нэн тэргүүнд тавих шаардлагатай. Үүнтэй холбоотой хуульчдад дээд боловсрол олгодог тогтолцоо, их сургуулиудын магадлан итгэмжлэлийн асуудлууд, их сургууль төгсөгчдөд тавигдах шаардлага, хуульчийн мэргэжлийн шалгалт, үргэлжилсэн сургалтууд, гадаад хэлний мэдлэг, хуулийн фирмүүдийн хөгжил, арбитр, дагнасан шүүхийн асуудлуудыг нарийвчлан ярилцах нь зүйтэй.

Хууль эрх зүйн шинэтгэл явагдаж, тогтвортой байдал хангагдсанаар улс орны эдийн засгийн хөгжил эрчимждэг.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль 2013 онд шинээр батлагдан өмгөөлөгч, прокурор, шүүгчийг эгнээдээ нэгтгэсэн Монголын хуульчдын холбоо үйл ажиллагаагаа явуулаад гурван жил болж байна. Хуульчдын холбоо нь хуулиар олгогдсон эрх үүргээ бүрэн хэрэгжүүлж чадвал Монголын хуульчдын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх хуулиар олгогдсон боломж юм.

Монголын Хуульчдын холбооны зүгээс явуулж буй сургалтууд агуулга, чанарын хувьд жилээс жилд сайжирч, сургалтын шинэ бодлого боловсруулж байна. Гэхдээ хуульчийн ажлын туршлага, амжилт нь хэзээ ч зөвхөн сургалтаар олддоггүй, практик дээр ажиллаж, уйгагүй хөдөлмөрлөж байж мэргэшил, туршлага, амжилт ирдэг. Энэ нь хууль зүйн салбарын онцлог юм. Ийм чадварлаг, шударга хуульчдыг хуульчийн мэргэжлийн шалгалтаар оруулж

шалгаруулах нь чухал.

Монголын хуулийн фирмүүд хүний нөөцийн болон эдийн засгийн хувьд хүчирхэг чадварлаг болох ёстой. Мөн төгс мэргэжлийн үйлчилгээг хэвшүүлж олон улсын хуулийн компаниудтай өрсөлдөхүйц хэмжээнд хүрнэ.

Нөгөө талаар Монгол улсад арилжаа, худалдаа, концесс, ашигт малтмал, татварын зэрэг бизнесийн маргааныг шийддэг дагнасан шүүх байгуулах боломжтой бөгөөд хууль эрх зүйн орчин нь нээлттэй. 2014 оны Монголын эдийн засгийн форумын Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн салбар хуралдаан дээр яригдсан дагнасан шүүхийн асуудлыг ажил хэрэг болгох шаардлагатай.

Дэлхийн эдийн засгийн форумаас 2016 онд гаргасан Өрсөлдөх байдлын тайлангаар Монгол Улс өрсөлдөх чадвараараа 140 орноос 104-т жагссан. 2015 онд 98-д эрэмбэлэгдэж байсан ч зургаан байраар ухарсан гэсэн үг. Энэ үнэлгээний нэг чухал хэсэг нь шүүгчдийн хараат бус байдал, мэргэшил, шүүгчдийн томилогдох ажиллагаа бөгөөд Монгол Улс энэ хэсэгт харьцангуй хойгуур жагссаныг ч бас анхаарч дүгнэлт хийх ёстой.

Мега төслүүдэд манай хуульчид болон гаднын хуульчидтай хамтран оролцох боломжийг бүрдүүлэх, гадаад хуульчид болон хуулийн фирмүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх хэрэгцээ шаардлага бий.

Мөн ажил амьдрал дээр хуульчдын гол зэвсэг болсон хэрэгжиж байгаа хууль тогтоомж болон шүүхийн практикийн судалгаанууд өнөөдөр дутагдалтай байгааг анхаарах нь зүйтэй.

Дээр дурьдсан болон даяаршсан дэлхийн эдийн засгийн болон нарийвчилсан салбаруудын хууль эрх зүйн хөгжил хаана явна, бид тэр хөгжилтэй мөр зэрэгцэн алхаж чадаж байна уу гэдэг асуудлуудыг энэ удаагийн эдийн засгийн чуулганаар ярилцана.

Эдийн засгийн чуулган энэ жил Сургамж, сорилт, шийдэл уриан дор зохиогдож байна. Тиймээс хэлэлцүүлгийн үр дүнг хууль тогтоогч, гүйцэтгэх засаглалын холбогдох байгууллагад хүргэж шийдвэрлүүлэхэд хяналт тавьж ажиллах төлөвлөгөөтэй байна. ■



Ёс зүй

Шуурхай чанар ба сайн бүтээл

Ц.ЭЛБЭГ

Америкийн кино академийн шагнал “Оскар”-ын энэ оны шилдэг киногоор Spotlight шалгарсан. Бостон хотын Католик сүмийн номлогчид бага насны хүүхдийг бэлгийн мөлжлөгт ашигладгийг “The Boston Globe” сонины эрэн сурвалжлах албаны сэтгүүлчид илчлэн харуулж буй тухай өгүүлэх уг киноноос сэтгүүлчдэд анзаарч, анхаарах зүйл бий. Уг кинонд арай өөр практик гардаг юм. Мөшгиж буй хэргийнхээ талаар хөдлөшгүй олон баримт цуглуулсан боловч нийтлэлээ хэвлэлгүй хагас жилийг өнгөрөөдөг. Өнөөх сэтгүүл зүйн шуурхай чанар яав?

Spotlight кино сэтгүүлчийн ёс зүйн тухай биш л дээ. Харин нийгэмд бугшсан ёс бус үйлийг хүчтэй, булгаж зайлах аргагүйгээр дэлгэн гаргаж буй тухай юм. Тэд олдсон баримт, материал бүрээ маргаашийн дугаарт хэвлүүлэх гэж яардаггүй, олон тооны хохирогчтой уулзаж баталгаажуулдаг. “Өнөөдөр сэтгүүлчдийн хамгийн их гаргаж буй ёс зүйн алдаа нь баримтыг нягтлалгүй нийтэлдэг, сураг, таамгаар бичдэг, үзэл бодлоо тусгадаг зэрэг санамсаргүйгээс үүдэлтэй байдаг” хэмээн Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүйн хорооны гишүүн Ц.Чимэддондог ярьсан юм.

Сэтгүүл зүйн мэргэжилтний ёс зүйн асуудал хэзээнээс л чухал асуудал байж иржээ. Ер нь ёс зүй нь хүний харилцаанд илүү хамаарах ойлголт аж. Философийн тайлбар нь “ёс заншил, зан төлөв, зан араншин, сэтгэлгээний хэв маяг” гэсэн агуулгатай гэжээ. Сэтгүүл зүй нь нийгмийн хамгийн өргөн хүрээг хамарсан олон нийтийн харилцаа болохын хувьд энэ салбарын мэргэжилтний ёс зүй юу юунаас илүүтэй хөндөх сэдэв юм. Гэхдээ одоо тэр байр сууриа социал медиад алдаж байж мэдэх.

Монголын сэтгүүлчид 1980-аад оны үеэс асуудалд нухацтай хандаж хариуцлага хэмээн авч үзэх болжээ.

Ерөнхийдөө диплом өвөртөлсөн, мэргэжлийн хэн бүхэн ёс зүйтэй байхын утга учрыг мэддэг гэж хэлж болно. 1990-ээд он гарснаас хойш сэтгүүл зүйн салбарынхны баримтлах ёс зүйн хэм хэмжээг Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл кодлон баталж ирсэн бөгөөд хэд хэдэн удаа дахин боловсруулж байв. Түүнээс гадна сэтгүүл зүйн байгууллага, редакци бүр дотоод онцлог, бодлогод нийцүүлэн өөрсдийн ёс зүйн дүрмийг ч боловсруулж мөрддөг. Харин сүүлийн нэг жилд бараг бүх сэтгүүлч, редакци нэг л ёс зүйн дүрмийг хүчин төгөлдөр мөрдөх болж байгаа. Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл хэмээх ТББ байгуулагдаж Монголын сэтгүүл зүйн нэгдсэн эвлэл, мэргэжлийн холбоод, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллүүд нэгдэн ёс зүйн хэм хэмжээгээ дахин боловсруулсан юм.

Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл нь сэтгүүлчийн ёс зүйн алдаа дутагдлын дагуу арга хэмжээ авдаг бие даасан байгууллага болон төлөвшиж байна. Тэр арга хэмжээ нь ямар нэгэн захиргааны шийтгэл бус. Салбарын онцлог, давуу талыг ашиглан алдаа доголдол гаргасан редакцийг олон нийтэд зарлах хэлбэрээр хариуцлагыг ногдуулдаг. Гэхдээ тус байгууллага нийтлэл, нэвтрүүлэг бүрийг шүүн тунгааж хэлэлцдэггүй. Зөвхөн ирүүлсэн гомдлыг Сонин, сэтгүүл, сайтын болон Радио, телевизийн ёс зүйн хороогоор авч хэлэлцэн ёс зүйн хэм хэмжээг зөрчжээ гэж үзвэл зохих арга хэмжээг авдаг байна. Хоёр хороо нь тус бүр хэвлэл мэдээллийн байгууллагын эзэн, сэтгүүлч, судлаач, хуульчдаас бүрдсэн 15 гишүүнтэй.

Хаа очиж ирсэн гомдлыг хэлэлцэх явцад тухайн редакциас ирсэн тайлбарт өөрийн бурууг илт хаацайлсан тохиолдол одоогоор гараагүй гэж Ц.Чимэддондог хэлсэн. Хэлэлцсэн буруутай тохиолдол бүрт өөрсдийн алдаа дутагдлыг шударгаар хүлээн зөвшөөрөх ёс суртахуун дийлэнх редакцид бий аж.

Ерөөс ёс зүйн асуудлыг авч хэлэлцэх хамгийн эхний шаг нь редакци юм. Бүх нийтлэл, нэвтрүүлэг редакцийн бодлогын шүүлтээр орж байж олон нийтэд хүрэх учиртай. Тиймээс ёс зүйн алдаатай сэтгүүл зүйн бүтээл бүрийн өмнө тухайн редакци хариуцлага хүлээх нь зүй ёсны юм.

Нөгөө талаас мэргэжлийн ёс зүйг хувь хүний ёс зүйгээс ялгаж салгаж ойлгох нь зөв. Өдөр тутмын харилцаанд орохдоо хувь хүний зан араншинд гарч буй доголдлыг мэргэжлийн хариуцлагатай хольж хутган редакцийн үйл ажиллагааг үнэлэх нь учир дутагдалтай. Харин тэр доголдол нь телевиз, радиогийн нэвтрүүлэг, сонин сэтгүүлийн нийтлэлд нь тусгагдаж үндэслэлгүй гүтгэн доромжилж, буруу дүгнэж, дайрч давшилсан зэргээр илэрч байвал түүнийг мэргэжлийн ёс зүйтэй хамаатуулж болно.

Өөр нэг зүйлийг дурдахгүй өнгөрч



болохгүй нь сэтгүүл зүйн бүтээлийг сэтгүүл зүйн бусаас ялгаж салгах асуудал. Телевизээр, цахим сүлжээгээр хүрч буй ярилцлага нэвтрүүлэг бүхэн сэтгүүл зүйн бүтээл биш. Зарим нэвтрүүлэг, шоу нь үзэгчийг зөвхөн өөртөө татах, зугаацуулах үүрэгтэй байдгаараа кинотой төстэй. Мөн телевизийн хөтлөгч, нэвтрүүлэгч бүр сэтгүүлч биш. Өнөөдөр мэдээллийн хэрэгслийн тоо олширсныг дагаад тэнд ажиллагсад мэргэжлийн бус ▶

► байх нь элбэг болсон. Энэ нь зөвхөн манайд ч байдаг үзэгдэл биш бөгөөд зарим төрлийн ток шоу, энтэртаймэнт нэвтрүүлгүүдийг бэлтгэхэд заавал мэргэжлийн сэтгүүлч байх шаардлага ч үгүй. Гэхдээ олон нийтийн харилцаанд оролцож байгаагийн хувьд ёс зүйн хэм хэмжээг баримтлах шаардлага бий. Гэвч тэдгээр мэргэжлийн бус хүмүүст энэ талын мэдлэг хангалттай бус.

Мэргэжлийнхэн ч мөн алдаа гаргадаг. Хэдийгээр их, дээд сургуульд сэтгүүл зүйн мэргэжилтнийг бэлтгэхдээ мэргэжлийн ёс зүйн хичээл заадаг ч өмнө дурдсанчлан хайхрамжгүй, хөнгөн хуумгай байдлаас үүдэж буй алдаанаас гадна зориудын ноцтой ёс зүйгүй алдаа гаргах нь цөөнгүй. Тухайлбал, сүүлийн үед хурцаар тавигдаж буй хаалтын гэрээ, захиалгат нийтлэл. Үүнээс гадна редакци өөртөө олж авсан баримтыг эс нийтлэх нөхцөлтэйгөөр мөнгө нэхэх муухай арга олсон гэх мэт

хангалттай байсан учир Монголын хэвлэлийн зөвлөлөөс хэвлэл мэдээллийн байгууллагын нэрийг нь зарлаж олон нийтэд мэдээлсэн юм.

Гэвч эцэстээ ёс зүй гэдэг нь сэтгүүлчийг хянах, дарамтлах гэхээсээ ур чадвараа сайжруулах, аливаа хариуцлагаас өөрийгөө хамгаалах боломж гэж хүлээн зөвшөөрөх нь чухал. Өнөөдөр редакциудын гаргадаг “муухай зан” нь асуудал гарахад бүх хариуцлагыг сэтгүүлчид үүрүүлдэг явдал. Хэрвээ нэр төрд халдсан дээрхтэй ижил тохиолдолд гомдол гаргагч шүүхэд хандсан бол сэтгүүлч захиргааны шийтгэл хүлээнэ. Сэтгүүлчийг шүүхэд очихоос өмнө асуудлыг эвлэрүүлэн зуучлах маягаар асуудлыг шийдэж хохирогчийг гомдолгүй болгож, сэтгүүлчийг ямар нэгэн дарамтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломж олгож байгаад Хэвлэлийн зөвлөлийн утга учир оршино.

шаардлага байгаа. Ялангуяа хэвлэл мэдээллийн байгууллагуудтай харилцаа холбоогоо сайжруулах, ёс зүйн зарчмаа таниулах, сэтгүүл зүйн ёс зүйн талаарх ойлголтыг иргэд, олон нийтэд түгээх. Мөн хараат бус байхын тулд санхүүгийн бэрхшээлийг гэтэлгэх хэрэгтэй. Олон улсын туршлагаас харахад Хэвлэлийн зөвлөл ихэнх нь хэвлэл мэдээллийн байгууллагуудын хандиваар болон, Улсын төсвөөс тодорхой хэмжээний санхүүжилт авдаг байна. Хэвлэлийн зөвлөлийн үйл ажиллагаа нь шүүхийн зардлыг бууруулдаг, чөлөөт хэвлэлийн үйл ажиллагааг дэмждэг тул Засгийн газар нь онцгойлон дэмждэг аж. Санхүүжилтийн гурав дахь эх үүсвэр нь олон нийтийн хандив. Монголын хэвлэл мэдээллийн зөвлөл өнгөрсөн хугацаанд гишүүдийн хандиваар үйл ажиллагааны зардлыг зохицуулж ирсэн бол ёс зүйн хорооны гишүүдэд чадавхижуулах ажлыг гаднын төсөл хөтөлбөр, тусламжаар шийдэж



ёс зүйгүй үйлдэл нэмэгдэх шинжтэй. Тухайлбал, сүүлд гарсан ёс зүйн алдааны жишээ “mongolcomment.mn” сайтын “Улаанбаатар буян компани бурхан болоочтой зүй бусаар харьцаж байна” гэх нийтлэл. Нэгдүгээрт, баримтаа нягтлаж шалгаагүйгээс компанийн нэр хүндэд халдсаны дээр тус компани руу урьдчилан холбогдож 20 сая төгрөг өгвөл нийтлэхгүй гэжээ. Гомдол гаргасан “Улаанбаатар буян” компанийн зүгээс баримт нотолгоо

Эргэн Оскарын шагналт киногоор жишээ татахад хариуцлага, ёс зүйгээ ухамсарлаж баримт материалаа нягталж, баталгаажуулж бултаж зайлах аргагүй дацтай бүтээл туурвиснаар илүү том амжилт, нийгэмд тустай үр дагаварт хүрдэгийг Spotlight-аас харж болно.

Монголын хэвлэлийн зөвлөлийн хувьд үүсгэн байгуулагдаад нэг жил болж буй шинэ байгууллага. Тэр ч утгаараа үйл ажиллагаагаа жигдрүүлэх

иржээ. Тухайлбал, Deutsche Welle, Fridrich Ebert сан, ЕАБХАБ-аас нэг бус удаагийн төсөл хэрэгжүүлж, төрөл бүрийн сургалтад хамрагдсан байна. Германы хэвлэл мэдээллийн зөвлөлийн нэг өдрийн хуралд хүртэл сууж туршлага судалжээ. Цаашид санхүүжилтийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх шаардлага байгааг тус байгууллагын удирд дэд дарга У.Тамир хэлж байлаа. Энэ жил байгууллагынхаа санхүүгийн төлөвлөгөөг гаргах талаар Англиас зөвлөх авах гэж байгаа аж. ■



МОНГОЛЫН БИЗНЕСИЙН ЗӨВЛӨЛИЙН АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТ

Монгол улсын бизнесийн тогтвортой өсөлт ба хөгжлийг дэмжинэ

Оролцохын ач холбогдол?

Монголд үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллага, мэргэжлийн хүмүүст ирээдүйд өсөж, хөгжихөд нь хэрэг болохуйц өргөн хүрээний, чухал бөгөөд шинэлэг мэдээ мэдээллийг олж авах

Дараагийн Засгийн газрын зүгээс анхаарвал зохих өнөөгийн бизнесийн салбарт тулгамдаж буй гол асуудлуудын талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэх; Засгийн газар, улс төрийн намууд болон холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэх Чуулга уулзалтын зөвлөмж бичигт өөрийн хувь нэмрийг оруулах

Хамрах хүрээ?

Бизнесийн төрөл бүрийн салбарын төлөөлөл болсон 200 хүн
Илтгэгч болон салбар хуралдааны зочдоор оролцох өндөр түвшний бизнесийн удирдагч, шийдвэр гаргагч 25 хүн

Платинум спонсор:



Алтан спонсор:



Мөнгөн спонсор:



Хэвлэл мэдээллийн спонсор:



Дэмжигч байгууллага:



Арга хэмжээний спонсор:



МБЗ чуулга уулзалтын дараах Хаврын Гала Үдэшлэгийн спонсор:



2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Blue Sky зочид буудал



ХӨГЖЛИЙН ГОЛОМТ

Бид нийгмийн хөгжлийн
тулгуур нь байж сайн сайхныг
түгээж ажилладаг

 **ГОЛОМТ БАНК**
Сайн сайхныг санхүүжүүлнэ

 www.golomtbank.com

Хууль

Амьдралын хуримтлал

Ц.БУЯН

Эв санааны нэгдлийн зарчимд тулгуурласан тэтгэврийн тогтолцоо ирээдүйд улам л ачааллаа дийлэхгүй болох нь. Өнөөдөр дунджаар 10 хүний нийгмийн даатгалаар нэг өндөр настны тэтгэврийг олгож байгаа бол 2080 онд энэ харьцаа 1x1 болно. Өөрөөр хэлбэл таны бараг л цалинтай ижил хэмжээний шимтгэлийг нийгмийн даатгалд тушаах хэрэгтэй гэсэн үг. Энэ зарчмаараа явбал шүү дээ.

Гэхдээ “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ыг өнгөрсөн оны зургадугаар сарын 16-нд УИХ баталсан юм. Бодлогын зорилгыг “Ахмад настны амьжиргаанд хүрэлцэхүйц зохистой хэмжээний тэтгэвэр олгох тогтолцоог бүрдүүлэхэд оршино” хэмээжээ. Ирээдүйд тэтгэврийн сан бүрдэхгүй болох эрсдэлээс өмнө тогтоолгосон тэтгэвэр нь амьжиргаанд нь хүрэлцэхгүй байгаа зовлон нүүрлээд байна. Өнөөдөр бодит байдал гэвэл тэтгэвэр авагчдын 60 гаруй хувь нь хуулийн доод хэмжээгээр тэтгэвэр тогтоолгосон, 70-80 хувь нь тэтгэврийн зээлд хамрагдаж байна.

Ийнхүү нэгэнт баримтлах бодлого тодорхой болсон учир түүнд нийцүүлэн хуулиа шинэчлэх ажил одоогоор хийгдэж байна. Бодлогын баримт бичигт хамгийн тодорхой зааж өгсөн зүйл нь эв санааны нэгдлийн тогтолцооноос хуримтлалын буюу өөрийгөө санхүүжүүлэх тогтолцоо руу хийх шилжилт. Энэ нь товчхондоо ирээдүйд авах тэтгэврээ та өөрөө бүрдүүлнэ гэсэн үг.

1979 оноос хойш төрсөн Монгол Улсын иргэн тэтгэврээ нэрийн дансны тогтолцоогоор тогтоолгоно. Энэ нь шимтгэлээс хийсвэр тооцох тэтгэврийн тооцоо буюу эв санааны нэгдэл, хуримтлалын хосолсон арга юм. Өөрөөр хэлбэл иргэний тэтгэврийн

санхүүжилтийг хөдөлмөрийн насныхан бүрдүүлэхээрээ эв санааны нэгдэлтэй адил боловч тэтгэвэр тогтоолгогчийн хөдөлмөрлөж байх хугацаанд төлсөн шимтгэлд үндэслэн хуримтлалын дүнг хийсвэрээр тооцох арга юм. 1960-1979 онд төрсөн иргэдийн хувьд нэрийн данс болон, цалин хөлс, шимтгэл төлсөн хугацаанд суурилсан тогтолцооны аль таатай нөхцөлөөр тэтгэврээ тогтоолгох сонголт эдлэх юм. Нэрийн дансанд зөвхөн ажиллагчдын өөрсдийнх нь төдийгүй ажил олгогчоос төлсөн шимтгэл хураамжийг нэмж бүртгэнэ. Энэ тогтолцоо бодлого хэрэгжих хугацаа дуусах хүртэл буюу 2030 он хүртэл хүчинтэй бөгөөд түүнээс хойш хагас хуримтлалын, цаашлаад бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжих юм.

Үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор хөндөгдөж буй өөр нэг асуудал нь тэтгэвэрт гарах нас. Одоогоор хуулийн төслүүд боловсруулах шатандаа яваа учир эцэслэн шийдсэн зүйл байхгүй. Гэвч бодлогын баримт бичигт “Эрэгтэй, эмэгтэй даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны доод хязгаар ижил байх” гэсэн өгүүлбэр

бий. ХАХНХЯ-ны мэргэжилтнүүд, хууль боловсруулж буй мэргэжилтнүүд одоогоор энэ асуудлыг судалж байна хэмээн Нийгмийн даатгалын албаны дарга А.Хишигбаяр ярьсан юм. Үүнтэй холбоотой нэг тоо баримт дурдсан нь эрэгтэйчүүдийн тэтгэвэр авдаг дундаж жил 10 бол эмэгтэйчүүдийнх 22 жил байгаа ажээ. Хүн амын хөгжил, өсөлтийг дагаад 2085 онд дунджаар эрэгтэйчүүд 20 жил, эмэгтэйчүүд 25 жил тэтгэвэр авна гэсэн урьдчилсан тооцоолол байдаг аж. Энэ нь мөн л тэтгэврийн даатгалын сан алдагдалд орохын шинж. Энэ бүхэн их хол мэт санагдаж байгаа ч асуудал ойрхон иржээ. 2020 оноос манай улсын хүн амын дотор өндөр настны эзлэх хувь нэмэгдэх хандлага гарч эхлэх бөгөөд 2028 он гэхэд 100 даатгуулагч тутамд 55 өндөр настан ноогдох аж.

Төрийн бодлогод тодорхой тусгасан зарим өөрчлөлтийг сонирхвол “эхчүүдийн хүүхдээ асарсан хугацааг тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, ажилласнаар тооцно” гэжээ. Мөн хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж хуульд тогтоосон наснаас эрт тэтгэвэр тогтоолгох тохиолдолд ▶



▶ тэтгэврийн насанд хүртэлх тэтгэмжийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас гаргадаг болох аж. Ингэхдээ хэвийн бус нөхцлөөс “хөдөлмөрийн хүнд нөхцөл” хасагдаж мэдэхээр байна. Учир нь техник технологийн дэвшлээс хамаараад хүнд нөхцөл арилж байгаа гэж үзэж байгаа аж.

Ямартай ч төрөөс “Монгол Улсын ахмад настан бүр орлогын наад захын баталгаат тэтгэврээр хангагдах” бодлого баримталж буй. Үүнийг хангахын тулд хүн бүр суурь тэтгэвэртэй байх, түүн дээр ажилласан хугацаанаас хамааран авах тэтгэвэр нь нэмэгддэг болох асуудлыг судалж байгаа аж. Үүнээс гадна нийгмийн даатгалын давхар тогтолцоо бий болгох юм. Хэрэв даатгуулагч хангалттай орлоготой бол хувийн тэтгэврийн даатгалын санд давхар хуримтлал үүсгэх боломж бүхий эрх зүйн өөрчлөлтийг хийх юм. Энэ нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт багтсан асуудал.

Түүнчлэн төрийн бодлогод малчдын нийгмийн даатгалын асуудлыг онцгойлон авч үзжээ. Эдийн засгийн

идэвхитэй хүн амын 30 гаруй хувийг бүрдүүлдэг ч нийт малчдын 11 хувь нь л нийгмийн даатгалд хамрагддаг ажээ. Тэд сайн дураар даатгуулах боломжтой боловч тогтмол мөнгөн орлогогүй, хөдөөнөөс хот руу шилжих зэргээр ажлын байршил, мэргэжил тогтвортой биш, өөрөө өөртөө найдах хандлага өндөр, албан салбарт ажиллах боломж бага зэрэг нь нийгмийн даатгалд хамрагдаж чадахгүй байх шалтгаан болж байна. Сүүлийн таван жилд малчдын зөвхөн 4.3-11.1 хувь нь тэтгэврийн даатгалд сайн дураар хамрагдсан нь ирээдүйд малчдын дийлэнх нь тэтгэвэр авах бололцоогүй болохыг харуулж байгаа юм.

Иймд малчдын нийгмийн асуудлыг шийдэх зорилгоор “Малчны тэтгэврийн даатгалын хууль”-ийг тусгайлан боловсруулах ажил одоо үргэлжилж байгаа аж. Мөн УИХ-д яг энэ асуудлаар “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг хэлэлцэхээр болсон. УИХ-ын гишүүн Д.Батцогтын өргөн мэдүүлсэн уг хуулийн төсөлд “малчдын

шимтгэл төлж, ажилласан нэг жилийг нэг жил хоёр сараар нэмэгдүүлэн тооцох” асуудлыг хөнджээ. Ингэснээр тэдний тэтгэврийн даатгалд хамрагдах сонирхлыг нэмэгдүүлэн хөдөлмөрийг нь бодитой үнэлж, цөөн жил шимтгэл төлснөөр өндөр насны тэтгэвэр авах эрх нь үүснэ гэж үзэж байгаа аж.

Энэ бүхний эцэст өөрийн тэтгэврийг өөрөө хуримтлуулах тогтолцоонд 40 жилийн дараа мөнгөний ханш ямар байж, бодитой хуримтлал болж миний амжиргаанд хүрэлцэх үү гэдэг асуулт үлдэж байна. Хариу нь “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай” хуульд байгаа. Өнгөрсөн нэгдүгээр сарын 22-нд батлагдсан уг бие даасан хуулиар энэ асуудлыг зохицуулж байгаа. Даатгуулагчийн нэрийн дансан дахь хөрөнгө ипотекийн зээлийн санхүүжилт болж, түүний эргэн төлөлтөөр зах зээлд хөрвөж, хүү бодогдон арвижих юм. Мөн ахин хэлэхэд Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулиас бусдаар дээр өгүүлсэн асуудлууд одоогоор судлагдаж байгаа, хараахан хуульчлан батлагдаагүй төдийгүй хуулийн төсөл нь ч эзлэн болоогүй байна. ■



Фотог Б.Бямба-Очир

Эрүүл мэнд

ҮЛ ИТГЭМ

Г.ОРХОН

Монгол Улсын хүн амын 15 хувь нь элэгний С, 10 хувь нь В вирусын халдвартай гэж үздэг. Өөрөөр хэлбэл, дөрвөн хүн тутмын нэг нь элэгний ямар нэг вирустэй байх нь. Гэтэл тэд бүгд вирустэй гэдгээ мэддэггүй, эсвэл бүр хожуу мэддэг нь харамсалтай. Элэгний өвчлөл нь хүнд шатандаа орчихсон яах учраа олохгүй аль сайн гэсэн эмч, эмнэлгийн хаяа бараадан яваа хүн цөөнгүй.

Тэдгээрийн нэг болох Баянзүрх дүүргийн зургадугаар хорооны иргэн Д.Энхтүвшин элэгний С вирусстэй гэдгээ мэдээд таван жил болж байгаа бөгөөд түүний элэг өвчлөлийн дөрөвдүгээр үе рүү оржээ. Өөрөөр хэлбэл Энхтүвшингийн элэг хатууралтай болсон гэсэн үг. Тэрбээр “Эрт мэдсэн бол ядаж тамхи татахгүй байх байлаа. Одоо дахин хэдэн жил амьд явахыг хүсч байна шүү дээ” хэмээн харамсан ярьсан. Түүний хувьд вирусээ устгавал элэгнийх нь одоогийн хатуурч, үхэжсэн хэсэг эдгэхгүй ч ядаж эрүүл хэсэг нь төлжих нь. Хэрэв үгүй бол ариун биедээ мэс хүргэхээс өөр аргагүйд хүрэх ч Энхтүвшин өнөөдөр вирусын эмчилгээгээ хийлгэж чадахгүй явна. Монголд хөнгөлөлттэй үнээр орж ирээд буй Харвони гэх эмийг хэрэглэхэд түүнд хамгийн багадаа долоон сая төгрөг шаардлагатай болох аж. Түүний адил санхүүгийн чадамж тааруу, мөн эм байтугай өдрийн хоолоо яая гэж буй хүн манай улсад цөөнгүй байгаа бөгөөд тэдний зарим нь элэгний эмчилгээний зардлынхаа тодорхой хувийг эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлүүлэх хүсэлтэй байна. Гэтэл манайд ийм хууль эрх зүйн орчин нь хараахан бүрдээгүй. Энхтүвшин улсад тасралтгүй 21 жил даатгал төлчихсөн бөгөөд үүнийхээ хөнгөлөлтийг эдлэх санаа өвөртөлж, эмчилгээгээ хийлгэж чадалгүй өдийг хүрчээ. Энэ талаар НИТХ-ын төлөөлөгч, Эрүүл мэнд хүнсний аюулгүй байдлын

байнгын хорооны дарга Ж.Амарсанаа “Харвони эмийг даатгалд зайлшгүй хамрагдах эмийн жагсаалтад оруульа гэх хүсэлтийг салбарын яам болон Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд тавьсан. Тэд ажлын хэсэг гаран ажиллаж байгаа гэсэн. Эмийн үнийг яг хэдэн хувиар хямдруулах гээд байгаа, ямар хөнгөлөлт өгөх гээд бүх талаар тодорхой хариу авч чадаагүй” гэсэн.

Элэгний С вируссыг “устгагч” гэж нэрлээд буй Софосбувир/Ледипасвир /арилжааны нэршлээр Харвони/ гэх эмийг Монгол АНУ-аас оруулж ирээд гурван сар болж байна. Эл хугацаанд тус эм үл итгэм үр дүнг өгч эхэлжээ.

Гурван саяас 30



Энэ эмэгтэйд О.Баярмаа гэдэг, Сүхбаатар дүүргийн 11-р хороонд нөхөр, хүүгийн хамт амьдардаг. Эмэгтэй хүний амьдрал 20 наснаас эхэлдэг гэдэг ч ид амьдралын 30 насыг дөрөөлж яваа тэрбээр элэгний С вирусстэй гэдгээ хоёр жилийн өмнө мэджээ. Баярмаа анх шинжилгээ өгөөд “вирусын үзүүлэлт нэг сая” гэх тоог хараад даруйхан арга хэмжээ авахыг хүсч эмнэлэгт хандсан байна. Тухайн үед Монголд С вирусын эмчилгээний ямар ч эм тан орж ирээгүй байсан бөгөөд жилийн хугацаанд дахин



шинжилгээ өгөхөд элэгн дэх вирус гурван сая болж үржсэн байж. Тэрбээр энэ оны нэгдүгээр сарын 4-нөөс Харвони эмийг ууж эхэлсэн. Баярмаа уг эмийг нэг хайрцаг буюу 28 ширхэгийг уугаад шинжилгээ өгөхөд вирусын үзүүлэлт нь гурван саяас 30 болж буурчээ. /30 гэдэг нь элэгний С вирус тоолдог аппаратын хамгийн доод нэгж/ Өөрөөр хэлбэл, түүний элэгн дэх вирусын 90 хувь нь устчихсан гэдгийг эмч нь дуулгасан байна.

Баярмаагийн нэг сарын эмийн зардал 400 ам.доллар гэхээр одоогийн байдлаар 1200 ам.долларын эм уугаад байгаа юм. Тэрбээр өөрийн сарын цалингаас нэлээд давсан үнээр эмээ худалдан авч ууж буй бөгөөд эхний хоёр сарынхаа эмийг цалингийн зээл авч байж уусан гэлээ. Харин энэ сарын эмээ авахад хүүхдийнх нь хадгаламж их хэрэг болж. Баярмаа “Хамгийн гол нь эдгэж байгаа болохоор мөнгөнд харамсаад байх зүйл алга. Залуу хүн болохоор эрт ▶



► эмчилж сайхан амьдармаар байна шүү дээ” гэж ярьсан юм. Эм уухаас өмнө түүний зүүн гарын мөрөн дээр овоо том сэвх үүссэн байж. Харин одоо нэлээд бүдгэрч, сэтгэл санаа нь хүртэл тогтвортой, бага зэрэг ядрахаас өөр зовиур үгүй болсон байна. Цаашид Баярмаа эмчийнхээ зөвлөснөөр эмээ ууж байгаад С вирусын вакцин хийлгэх бодолтой сууна.

Бүр 90 саяас 30

Баярмаагийн адил эл эмийг ууж, үр дүнг нь мэдэрч яваа нэгэн бол Баянзүрх дүүргийн зургадугаар хорооны иргэн Л.Багтулга. Гэхдээ түүний элгэн дэх С вирусын үзүүлэлт 2003 онд 90 сая байсан бол одоо вирусын хамгийн идэвхгүй түвшинд буюу 30 болж буураад байна. Шинжилгээнийхээ энэ хариуг хараад Багтулга нүдэндээ ч итгээгүй гэсэн. Тэрбээр Харвони гэх эмийг нэгдүгээр сарын 1-нээс ууж эхэлсэн бөгөөд одоо гурав дахь

сарынхаа эмийг ууж дуусч байгаа юм. Одоогоос 13 жилийн өмнө элэгний С вирус тээж яваагаа мэдээд бусдын л адил аль сайн гэсэн бүхнийг хэрэглэж, үүдийг нь татаагүй эмч, эмнэлэг байхгүй байж. Бүр хилийн дээс давж 2012 онд Япон улсад нарийн шинжилгээ өгөхөд түүний элэг нэлээд их үрэвссэн байсан бөгөөд арай ч хавдар болоогүй байсан аж. Багтулга “Тухайн үед Харвони эмний тухай сонссон. Тэгээд Монголд орж иртэл нь хүлээсний эцэст одоо үр дүнг нь биеэрээ мэдэрч сууна” гэлээ. Түүний хувьд эм уухаас өмнө маш их ядарч, нүд нь шарлаж, аргадаг байсан бол одоо “Нүд минь цэлмэх шиг болж, гурван ч кг жин нэмээд байна” хэмээв. Хувиараа аж ахуй эрхэлдэг болохоор тэрбээр ямар ч байсан эмчилгээнийхээ зардалд санаа зовохгүй байгаа аж.

Баярмаа, Багтулгын адил энэ эмийг ууж эхэлсэн 1600 орчим хүн тодорхой хэмжээгээр үр дүнг нь мэдэрч сууна. Харвони эмийг эм ханган нийлүүлэгч “Омбол” ХХК оруулж ирж байгаа

бөгөөд нэгдүгээр ээлжинд дээрх хүмүүсийн эмчилгээ болох 4800 ширхэг эмийг оруулж иржээ. Нэг хайрцгийг нь 400 ам.доллараар оруулж ирж буй бөгөөд иргэд тухайн өдрийн ханшаар худалдан авч байна. Харин дараагийн ээлжийн эм болох 2000 хүний эмчилгээний эмийг дөрөвдүгээр сард оруулж ирэх бөгөөд тус сарын 15-наас тараах тухай “Омбол” ХХК-ийн ажилтан хэлэв. Уг эм нь АНУ-д 96 мянган ам.доллар, Европод 50-60 мянган еврогоор зарагдаж байгаа аж. Харин манайд гурван сарын курс эмчилгээ нь 1200 ам.доллар. /АНУ-ын “Gilead Sciences” компани нь элэгний С вирусг эмчлэх Харвони /Ледипасвир 90 мг/Софосбувир 400 мг/ цахмал эмийг Канад улсын “Patheon” үйлдвэрт гэрээгээр үйлдвэрлүүлэн Монгол Улсад “Access” буюу “Хүртээмж” хөтөлбөрийн хүрээнд олон улсад нийлүүлэгдэж буй хамгийн хөнгөлөлттэй үнээр нийлүүлж байгаа юм./

Өнөөдөр жилдээ 1200 гаруй хүн элэгний хатуурлын улмаас нас барж байгаа гэх статистик байна. Гэтэл элэгний хатуурлын 62.5 хувь нь С вирусын гаралтай байдаг аж. Вирусг устгаснаар бид жилдээ 750 хүний амь, 20 жилийн хугацаанд 15 мянган хүний амийг аврах боломжтойг Ж.Амарсанаа ярьсан. Жилд 1400 хүн элэгний хорт хавдрын улмаас нас бардаг бол тэдгээрээс багадаа 40 хувь нь С вирусын гаралтай гэж үздэг. Энэ нь 20 жилд 11 мянган хүнийг элэгний хорт хавдраар нас барахаас сэргийлэх юм. Тэгвэл вирусг эмчилснээр ирэх 20 жилд 26 мянган хүний амь насыг аварч чадах гэнэ.

Одоогийн байдлаар эмчилгээ хийлгэж буй хүмүүсийн дийлэнх нь гурван сарын эмчилгээ хийлгэж байгаа бол зарим нь буюу өмнө интервонийн эмчилгээ хийлгээд үр дүн өгөөгүй хүмүүс дахин зургаан сарын эмчилгээнд хамрагдаж байгаа аж. Харин анх удаа С вирусын эмчилгээнд орж байгаа хүн гурван сарын хугацаанд эмчилгээ хийлгээд дуусах нь. ■

Нийслэлийн музей, Дурант тавцан
Capital city Museum, Observation Deck

“Монголд үйлдвэрлэв” Худалдааны төв
“Made in Mongolia” Shopping centre

Хуримын, Ёслолын танхим
Wedding & Ceremony hall

Ёслолын цэцэрлэг
Ceremony garden

Нэр: ИХ ЗАЙСАН ЦОГЦОЛБОР

Зориулалт: Соёл Амралтын Цогцолбор

Төсөл хэрэгжүүлэгч: Оюуны Ундраа Групп

Ашиглалтад орох хугацаа: 2016 он

Концертний танхим
Concert Hall

Цэцэрлэгт театр
Garden Theatre

Танктай хөшөө
Tank Statue

Автомашинь зогсоол
Car parking (200 cars)

Аялгуут оргилуур
Melody Fountain

Түргэн хоолны цэг
Fast food (6 types)



Хотыг Тольдох Ресторан, Лоунж
City View Restaurant & Lounge

VIP Ресторан
VIP Restaurant

Ресторан
Restaurant

Ёслолын гэр
Ceremony Ger

Спорт тоглоомын төв
Sport Games Center

Музей, Галлерей
Museum, Gallery

Номын өртөнц
Book Planet

Мөсөн гулгуурын талбай
Ice Skating Rink

Олон үндэстний зоогийн газар
Multinational food court

Ресторан
Restaurant

IT Төв
IT Center

Кофе шоп
Coffee shop

Үзүүлэнгийн танхим
Autoclub Showroom

Хувцас загварын төв
Fashion center

Кино театр
Cinema

